

МОДУЛЬ
8

**ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭЖ
БУЙ ХҮН ХУДАЛДААЛАХ
ГЭМТ ХЭРЭГ БА ИЛРҮҮЛЭЛТ**



МОДУЛЬ 8

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭЖ БУЙ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ИЛРҮҮЛЭЛТ

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар боловсруулсан: Гүнсэнчоймболын Амаржаргал

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Баяндалайн Баярмаа
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй НҮБ-ын “Итгэлцлийн Сан”-гийн санхүүжилттэй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд боловсруулж, хэвлүүлэв.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org | Модулийг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс 2023 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.	7
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	8
НЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨЖ ХОХИРСОН ХҮҮХДИЙГ ТАНЬЖ, ИЛРҮҮЛЭХ НЬ	10
1.1. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийг таних шинж тэмдэг	11
1.2. Хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэх ба гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаа	22
1.3. Хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэгт нотлогдвол зохих нөхцөл байдал	29
ХОЁР. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ-ХҮҮХДИЙН ӨМГӨӨЛҮҮЛЭХ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ	36
2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хохирогч-хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн эрх, үүрэг	37
2.2. Өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах	40
2.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах үндэслэл, журам	45
ХАВСРАЛТ.	49
Цагдаагийн албан хаагчийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга	49
Хилийн шалган нэвтрүүлэх албаны албан хаагчийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуулга.	51
Эрсдэл бүхий гадаадын иргэнээс авах асуулга.	53
НОМ ЗҮЙ.	54

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хүндэтгэн хангах, хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын, бие даасан, хараат бус иргэний нийгмийн байгууллага юм. ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь НҮБ-ын Итгэлцлийн Сан (UN Trust Fund)-гийн санхүүжилтээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг гурван жилийн (2021-2024) хугацаатай, нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын хороодын дүгнэлт зөвлөмжүүдэд охин хүүхдийг бэлгийн болон бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалж, хүчирхийллийн аливаа хэлбэрээс охидыг хамгаалах, нэр төрийг нь хүндэтгэхийг эрхэмлэх ёстойг онцлон тэмдэглэдэг. Монгол Улсад хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа хэдий ч жендэрт суурилсан хүчирхийлэл, охидын эсрэг хүчирхийллийн тоо буурахгүй хэвээр байгаад зовниж, Хүүхдийг Ивээх Сан охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилго тавин ажиллаж байна.

Төслийн хүрээнд бид хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх зорилго бүхий 11 модулиас бүрдэх багц гарын авлагыг боловсруулан та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Тус гарын авлага нь хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын тогтолцоо, салбарын ажилтнуудын оролцоо, үүрэг, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй (хохирогч/даван туулагчид ээлтэй) арга зүй, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ, кейс менежмент, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охидод үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, хүүхэд хамгааллын ажилтнуудын ажлаас халшрах хам шинжийн талаарх ойлголтыг өгч, хүүхдэд сэтгэцийн дам гэмтэл учруулахгүйгээр, цаг алдахгүй мэргэжлийн үйлчилгээг чанартай үзүүлэх үр чадварыг өсгөх зорилготой юм.

Олны хүч оломгүй далай гэдэг ээ.

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох, эрхээ ялгаварлалгүй эдэлдэг, хариуцлагатай нийгмийг цогцлоох үйлст хувь нэмрээ оруулж, сургалтын энэхүү багцын “Модуль 8. Хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах гэмт хэрэг ба илрүүлэлт” хэсэгт гэрээлэн ажилласан эрдэмтэн, судлаач Гүнсэнчоймболын Амаржаргалд болон Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багтаа талархал илэрхийлье.

Энэ чиглэлээр бидний нэгэн адил хувь нэмэр оруулж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байгаа зорилго нэгт, хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түншүүддээ талархал илэрхийлье.

Энхбатын Цолмон

ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

Багц гарын авлагын 11 модуль тус бүрийн хоорондын уялдаа холбоо, зорилгыг доорх хүснэгтэд харууллаа.

Модулийн нэр	Зорилго
Модуль 1 Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого	Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлага, хүүхдийн хамгаалагдах эрх, хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, бодлогын талаар онол, практик хэрэглээ, сайн туршлагыг танилцуулах
Модуль 2 Хүүхэд хамгааллын үйлчилгээ ба кейс менежмент	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх гэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин тус бүрд хамгааллын үйлчилгээ хүргэх, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээг хэрхэн хүргэх
Модуль 3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байрны үйлчилгээ	Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байранд байрлаж буй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нас, сэтгэцийн онцлогт тохирсон үйлчилгээг хэрхэн үзүүлэх, үйлчилгээг стандартын дагуу сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй байдлаар үзүүлэхэд анхаарах асуудал, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд анхан шатны болон хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх
Модуль 4 Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ	Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ, үйлчилгээнд хамруулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын үнэлгээний талаар үндсэн ойлголттой болж, хувилбарт үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний төлөвлөлт хийхэд баримтлах зарчим, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулах
Модуль 5 Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн давуу талд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэр дундаа нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар арга зүйн үндсэн ойлголт, онолын үндэслэлийн талаар мэдлэг нэмэгдүүлэх, мөн хүчирхэг болгох амьдрах ухааны ур чадварыг олгох нийгмийн ажлын арга зүй, хандлага зэрэг талаар мэдээлэл өгөх
Модуль 6 Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал	Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, хүүхдэд тохиолдох эрсдэл, үйлчилгээний зохион байгуулалт, удирдлага, кейс менежмент, урьдчилан сэргийлэлтийн талаар ойлголт өгөх.
Модуль 7 Хүн худалдаалах гэмт хэрэг ба жендэрт суурилсан хүчирхийлэл	Жендэрийн үндсэн ойлголт, түүний эрх зүйн зохицуулалт, үндэсний тогтолцоо, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний төрөл хэлбэр, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг илрүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар мэдлэг нэмэгдүүлэх

Модуль 8

Хүүхэд худалдаалах гэмт хэрэг-илрүүлэлтийн стратеги болон үйл явц

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, зохицуулалтын онцлог, хүүхдийг худалдаалж буй төрөл, хэлбэр, хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулах талаар нэгдсэн ойлголт өгөх.

Модуль 9

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагч төвтэй арга зүй

Сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт, төрөл, илрэх нийтлэг шинж тэмдэг, сэтгэцийн гэмтэл бие махбод, оюун санаа, сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаанд нөлөөлөх сөрөг нөлөө, дахин сэтгэцийн гэмтэлд урчлуулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчмуудын талаар ойлголт өгөх

Модуль 10

Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах нь

Ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинжийн ойлголт, үүсэх үе шат, нөлөөлөх хүчин зүйл тухай мэдлэг олгоно. Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжид өртөх шалтгаан, илрэх сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн бэлтгэх, ажлаас халшрах хам шинжийг үнэлэх аргачлал, түүнийг даван туулах сэтгэл зүйн заслын тусламжид суралцах болно.

Модуль 11

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинжүүд, хохирогч/даван туулагчдад илрэх сэтгэл зүйн болон бие махбодын шинжүүдийг ялган таньж мэдэх, сэтгэцийн гэмтлийн тухай ойлголт, төрөл, нөлөөлөх хүчин зүйлс, хүчтэй стресст өгөх цочмог хариу урвалын тухай ерөнхий ойлголт, гэмтлийн дараах стрессийн эмгэг, түүнд хэрэглэх сэтгэл зүйн зөвлөгөөний арга техникүүдийн талаар анхан шатны мэдээлэл өгөх.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
Палермогийн протокол	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв ТББ
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Бэлгийн дарамт ¹	бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзолыг хэлнэ;
Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч ²	гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.
Мөрдөгч ³	хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтаныг хэлнэ.
Мөрдөн шалгах ажиллагаа ⁴	хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагааг хэлнэ.
Мөрдөн шалгах нууц ажиллагаа ⁵	прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг хэлнэ.
Нийгмийн ажилтан ⁶	баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтаныг хэлнэ.
Нэг цэгийн үйлчилгээ ⁷	хохилогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг хэлнэ.
Томилогдсон өмгөөлөгч ⁸	хуульд заасан тодорхой нөхцөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийг хэлнэ.
Түр хамгаалах байр ⁹	хохилогчийг тодорхой хугацаагаар байрлуулан энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ.
Хамгаалалтын арга хэмжээ ¹⁰	гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйг хамгаалах арга хэмжээг хэлнэ.
Холбон зуучлах үйлчилгээ ¹¹	гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үзүүлэх үйлчилгээг хэлнэ.
Хохирогч ¹²	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ.

1 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2011. №8

2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017. №5

3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017. №3

4 Мөн тэнд

5 Мөн тэнд

6 Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №19, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэг

7 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017. №5

8 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017. №3

9 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017. №5

10 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2013, №30

11 Мөн тэнд

12 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2012. №7

Хохирогч ¹³	гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогчийг хэлнэ.
Хууль зөрчсөн хүүхэд ¹⁴	гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг хэлнэ.
Хүн худалдаалах ¹⁵	хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ.
Хүүхдийн эрхийн ажилтан ¹⁶	хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтаныг хэлнэ.
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо ¹⁷	гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг хэлнэ.
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ¹⁸	санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ.
Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ ¹⁹	эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг хэлнэ.
Хүчирхийллийн болзошгүй эрсдэл ²⁰	гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг хэлнэ.
Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд ²¹	эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ²²	гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ.

13 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №40, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх заалт

14 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016. №9

15 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2012. №7

16 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016. №9

17 Мөн тэнд

18 Мөн тэнд

19 Мөн тэнд

20 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017. №5

21 Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016. №9

22 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017. №3

НЭГ

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨЖ ХОХИРСОН ХҮҮХДИЙГ ТАНЬЖ, ИЛРҮҮЛЭХ НЬ

- 1.1 Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийг таних шинж тэмдэг
- 1.2 Хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэх ба гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаа
- 1.3 Хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэгт нотлогдвол зохих нөхцөл байдал

1.1

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨЖ ХОХИРСОН ХҮҮХДИЙГ ТАНИХ ШИНЖ ТЭМДЭГ

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас 2020 онд гаргасан мэдээлэлд хүн худалдаалах гэмт хэргийн нийт илрүүлсэн хохирогчийн гуравны нэг нь хүүхдүүд буюу 19 хувь эмэгтэй хүүхэд, 15 хувь нь эрэгтэй хүүхэд байна²³. Манай улсын хуулийн байгууллагын статистик мэдээлэлд ч мөн насанд хүрээгүй хүмүүс өртөж хохирох явдал жил бүр өсөн нэмэгдсээр байгаа нь харагдаж байна.

Зураг 1. Цагдаагийн байгууллагаас гаргасан хүн худалдаалах гэмт хэргийн статистик

Он	Эх-ийн 13.1-р зүйл /Хүн худалдаалах/				
	Хэрэг	Холбогдогч	Хохирогч		
			Нийт	Насанд хүрээгүй	Гадаад улсад хохирсон
2017	10	26	46	11	10
2018	10	19	42	12	22
2019	14	23	65	17	10
2020	10	18	37	18	15
2021	9	19	26	19	-
2022 эхний 5 сар	7	11	21	18	-
Нийт	64	116	237	95	57

Судалгаанд дүн шинжилгээ хийж үзвэл 2017 онд нийт хохирогчдын 23.9 хувь нь насанд хүрээгүй хохирогч байсан бол 2021 онд нийт хохирогчдын 73 хувь нь насанд хүрээгүй хохирогч болж даруй 2 дахин өссөн байна. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчид гадуурхагдсан, амьдралын хүнд нөхцөлд байгаа, хараа хяналтгүй, эдийн засгийн эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийг онилж, хохироож байна²⁴.

Манай улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа хүн худалдаалах гэмт хэрэгт ч мөн ялгаагүй гэр бүлийн таарамжгүй харилцаа, эдийн засгийн эмзэг байдалд байгаа насанд хүрээгүй охидыг өртүүлэх явдал байсаар байна²⁵. Цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн албанаас гаргасан мэдээллээс харвал хүн худалдаалах гэмт хэрэгт насанд хүрээгүй хүүхэд өртөж хохирох явдал жил бүр тогтмол өссөн үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна.

23 https://www.unodc.org/documents/data-and-analysis/tip/2021/GLOTiP_2020_15jan_web.pdf

24 https://www.unodc.org/documents/data-and-analysis/tip/2021/GLOTiP_2020_15jan_web.pdf

25 Эрүүгийн цагдаагийн албанаас хийсэн Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын танилцуулгаас.

Зураг 2. Хүн худалдаалах болон түүнтэй төсөөтэй зарим гэмт хэргийн сүүлийн 5 жилийн тоон судалгаа



Эндээс харвал хүүхдэд садар самууныг сурталчлах, түүнд татан оруулах замаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болгох, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх явдал тогтвортойгоор өсөх хандлага ажиглагдаж байна²⁶. Иймээс хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчид шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэхийн тулд нэн тэргүүнд хохирогчийг таньж, илрүүлэх нь хамгийн чухал асуудал болж байгаа юм.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь олон төрөл, хэлбэрээр илэрч, тухайн тохиолдол бүрт өөр өөр шинж чанарыг үзүүлж байдаг. Өөрөөр хэлбэл насанд хүрсэн, насанд хүрээгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүс хөдөө аж ахуй, мал аж ахуй, барилга, зугаа цэнгэл, загас агнуур, уул уурхай гэх мэт маш олон салбарт хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөж байдаг.

Модуль 7-д авч үзсэнчлэн хүн худалдаалах гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйл өөр өөр боловч хараа хяналтгүй, гэр бүлийн таарамжгүй харьцаа, амьдрал ахуйн хүнд нөхцөл, эдийн засгийн эмзэг байдалд буй хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх явдал амьдралд ихээр тохиолдож байна.

Бусдад гадуурхагдсан, гэр бүлийн тааламжгүй, хүнд хэцүү, бэрхшээлтэй амьдралаасаа зугтаахыг хүссэн хүүхдүүд сайхан амьдрахыг хүсч мөрөөдөхдөө тэдэнд ямар саад бэрхшээл тулгарч болох талаар бодож үзэлгүй, аюулыг урьдчилан мэдрэх ямар нэгэн туршлагагүйгээс бусдад мэхлэгдэж, илүү боломж амласан амлалтуудад хууртах явдал ажиглагдсаар байдаг. Хамгаалах, харгалзах хүнгүй хүүхдийг эрхшээлдээ оруулах нь гэмт хэрэгтнүүдийн хувьд хамгийн хялбар арга байдаг нь энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хүүхдүүдийн талаарх хэргийн материалаас харагдаж байна.

АНХААР!!!

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН БҮХ ТОХИОЛДОЛ ГЭР БҮЛИЙН ТААРАМЖГҮЙ БАЙДАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭМЗЭГ БАЙДЛЫГ АШИГЛАСАН БАЙДАГГҮЙ.

26 Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, Судалгааны тайлан, УБ., 2022

Амьдрал дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг тодорхойлох нь амар байхгүй ч болзошгүй эрсдлээс хүүхдийг хамгаалах, нэгэнт хохирсон хүүхдийг илрүүлж, шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэх нь төрийн үүрэг юм.

✓ Зөвлөмж

- Нөхцөл байдлыг зөв үнэлэх замаар хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй хохирогч мөн байж болзошгүй насанд хүрээгүй хүнийг илрүүлэх
- Анхан шатны нэгжид үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг тогтоож, шаардлагатай тусламж, хамгаалалтын арга хэмжээ авахын тулд энэ төрлийн гэмт хэргийн талаар тодорхой ойлголттой байх, зохих хариу арга хэмжээ мэдлэг, чадвартай байх
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг тогтооход шаардлагатай тодорхой шалгуур үзүүлэлтийг ашиглах

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тодорхойлж чадаагүйгээс мөлжлөгт өртсөн хэвэндээ байж, авах ёстой тусламж, хамгаалалтаа авч чадахгүйгээс гадна гэмт хэрэгтнүүдийг шүүхэд шилжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, нотлох баримт цуглуулж чадахгүйд хүрдэг.

Иймээс хохирогчийг илрүүлэн таньж мэдэх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдүүдийг яллах, хохирогчдод нэн шаардлагатай тусалцаа үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хамгаалах үйл явцын чухал хэсэг юм.

Салбар бүрийн албан хаагч, мэргэжилтнүүд хүн худалдаалах гэмт хэргийн талаар хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсныг ойлгож мэдсэнээр, мөлжлөгийн янз бүрийн хэлбэрүүдэд өртсөн байж болзошгүй хохирогчид болон тэдгээрээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж илрүүлэх магадлал өндөр байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг гаднаас нь хараад тогтооход хүндрэлтэй боловч нийтлэг шинжүүдээр анхан шатны байдлаар тодорхойлж болно. Хуульд заасан үндсэн шинжүүдээс гадна энгийн байдлаар ажиглахуйц олон шинжүүд байдаг. Хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид дараах нийтлэг шинж илэрч болно²⁷.

Хүснэгт 1. Хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд илэрч болох шинж тэмдэг

Хүүхдийн гадаад төрх байдал /эмнэлгийн нөхцөлд тогтоох/	Хүүхдийн биеэ авч явах байдал /ажиглалт, ярилцлагаар тогтоох/
<ul style="list-style-type: none"> - Дотуур хувцас нь урагдсан, цус, өөр бусад толбоор бохирлогдсон - Бэлэг эрхтний нь орчимд хөндүүрлэж өвдөх буюу загатнах - Гадна бэлэг эрхтэн, үтрээ, анусны орчимд хөхөрсөн, цус хурсан - Биеийн аль нэг хэсэгт эсхүл хувцас нь үрийн шингэн болсон - Бэлгийн замаар дамжих халдвар авсан болон жирэмсэн болсон 	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн зан авир нь бусдаас зай барьсан, зожиг байдалтай - Үеийнхнээсээ хол хөндий, тэдэнтэй харьцахгүй байх - Биеийн хүчний ямар нэгэн ажлаас зайлсхийх - Байнга хар дарж зүүдлэх, сайн унтаж амарч чадахгүй байх, харанхуйгаас айх - Сексийн талаар хэт их мэдлэгтэй байх, тухайн хүүхдийнхээ насанд тохироогүй зан байдал үзүүлэх - Хүнээс айх, ганцаар үлдэх, хэн нэгэнтэй байхаасаа дургүйцэх - Бусад үл ойлгогдох зан байдлууд илрэх гэх мэт.

27 Хамтын бүтээл, Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага /хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг/, УБ.,2019

Түүнчлэн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд дараах шинж байдлууд илрэх нь түгээмэл байдаг. Тухайлбал²⁸:

- **Томчуудад итгэх итгэлээ алдах:** Хэн нэгэнд итгэх итгэл, хайрлах, хайрлуулах мэдрэмж нь алдагдсан байдаг.
- **Эргэлзэх:** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж байгаа хүүхэд түүнд яг юу тохиолдоод байгаа талаар хүнд хэлэхээс айдаг. Энэ нь гэмт этгээд хохирогч хүүхдийг айлган сүрдүүлж, хүч хэрэглэсэнтэй холбоотой байдаг.
- **Өөрийгөө буруутгах, сэтгэл гутралд орох:** Тохиолдсон явдалд өөрийгөө маш ихээр буруутган, ичиж зовсноос бусадтай харьцах харьцаагаа таслан, ганцаардаж, сэтгэл гутралд ордог.
- **Өөрийгөө үнэлэх үнэлэмж нь буурах:** Өөрийгөө буруутган хэнд ч хэрэггүй болсон, ирээдүй байхгүй гэж үзэн хэт дотогшоо, эсвэл эрсдэлтэй зан үйлд татагдан орох магадлал өндөр болдог.
- **Өөрийгөө бэртээж гэмтээх:** Зарим хохирогч хүүхдүүд өөрийгөө тухайн үед энэ явдлыг таслан зогсоож чадаагүйдээ өөрийгөө үзэн яддаг. Энэ байдалд өртүүлэх бас нэг хүчин зүйл нь ар гэрийнхэн хүүхдийг буруутгах явдал юм.
- **Бэлгийн зан үйлийн эмгэгтэй болох:** Хохирогч хүүхдийн бэлгийн амьдралын тухай үзэл бодол, бэлгийн мэдрэмж нь хэвийн бус болдог. Тэдний зарим нь насанд хүрсэн хойноо болзоонд очихоосоо айх, хүнд итгэхгүй болсон байдаг. Мөн зарим хохирогч бэлгийн харилцаанд хэт их сонирхолтой, эсвэл дургүй, үзэн ядагч болдог байна.
- **Заналхийлэл, сүрдүүлэг:** Заналхийлэл нь үг хэлээр илэрдэг. Хэрэв мэдэгдвэл өөрийг нь болон гэр бүлийн гишүүдээс нь хамгийн хайртай хүнийг нь ална гэх мэтээр заналхийлдэг. Хохирогч нь бие даах чадваргүй, хүчирхийлэгч нь эрх мэдэлтэй, нөлөө бүхий хүн байдгаас ямар нэгэн аюултай зэвсэг хэрэглээгүй байсан ч заналхийлэл болон сүрдүүлэг үйлчилдэг.
- **Айдас:** Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн дараа ердийн нөхцөл ч аюулгүй биш санагдах болно. Энэ нь хохирогчийн гэр орон, сургууль, орчин тойронд хамааралтай. Байнга бодогдож, цочимтгой, хар дарсан зүүд, багтраа, уналт, таталт, гүн айдаст автуулж болох юм.
- **Гэр бүл:** Гэр бүл нь хохирогчийг чимээгүй байх, туслалцаа хүсэхгүй байлгах нэг шалтгаан болдог. Зарим тохиолдолд гэр бүлийнхээ нэр төрийг хамгаалж байна гэж бодож гэмт хэрэг гарсан ч мэдээгүй мэт нууж ил гаргадаггүй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хүн, хүүхдэд дараах шинж илэрч болно²⁹. Үүнд:

- Бусад хүмүүстэй нэг дор, ажлын байран дээрээ амьдардаг, тухайн байрнаас гарах нь ховор эсвэл огт гардаггүй байх
- Амьдарч буй байр сууц нь хүн амьдрах зориулалтын бус буюу хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн зориулалттай байр, байгууламж байх
- Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлгүй байх
- Хоол хүнсний үлдэгдлээр хооллох эсхүл хоолны чанар хэт муу байх
- Хөдөлмөрийн хөлсөө авч чадахгүй байх
- Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй байх
- Хэт олон цагаар ажиллах
- Ажил олгогчоос шууд хамааралтай нөхцөлд ажиллаж, амьдардаг байх
- Чөлөөтэй зорчих боломжгүй, хязгаарлагдсан нөхцөлд ажиллаж байх

28 Хамтын бүтээл, Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага /хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг/, УБ.,2019

29 НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хүн худалдаалахын хохирогчийг илрүүлэх, ярилцлага авах болон тусламж үйлчилгээнд хамруулах тухай заавар, УБ.,2017

- Ажлын байрнаас орж гарах хөдөлгөөнд хяналт тогтоох зорилгоор хатуу хяналт, хамгаалалттай байх
- Дарамталсан, айлган сүрдүүлсэн, хүчирхийлсэн байх
- Эрхэлж буй ажил хөдөлмөрийн талаар ямар нэг сургалтад хамрагдаагүй, тухайн мэргэжлийн бус эсхүл хуурамч бичиг баримттай байх зэрэг болно.

Харин төрийн байгууллага, албан тушаалтан албан үүргийг гүйцэтгэх, хяналт шалгалт явуулах үед дараах шинж илэрвэл хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч байх магадлалтайд тооцно.

Үүнд:

- Эрүүл ахуйн болон хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ самбар байхгүй
- Гадаадын ажилтан, мэргэжилтнийг ажиллуулахад шаардлагатай бичиг баримт байхгүй эсхүл хуурамч
- Ажилтнуудад олгож буй цалин хөлсний талаарх санхүүгийн баримт байхгүй эсхүл хуурамч. Ажилтанд олгож буй цалин хөлс нь тухайн ажлын байрны нөхцөлд тохироогүй бага байх
- Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн хэрэгсэл нь огт байхгүй эсхүл шаардлага хангахгүй болсон, хэт хуучин
- Энэ төрлийн хэрэгслийг хүүхдэд зориулж бэлтгэсэн эсхүл хүүхэд ашиглаж болохуйцаар тохируулсан
- Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж ноцтойгоор зөрчигдөж байгаа
- Ажилтан нь ажил эрхлэхдээ ашиглаж буй хэрэгслийн зардал, хоолны зардлыг өөрөө төлдөг эсхүл цалин хөлснөөс суутгадаг байх зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд нутагшаад буй гэрийн үйлчлэгч ажиллуулах явдал манайд нилээд түгээмэл болсон бөгөөд гэрийн үйлчлэгчийг хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлж байвал дараах шинж илэрч болно. Үүнд:

- Ажиллаж буй айлдаа хамт амьдардаг
- Амрах, хооллох, хувцас солих зэрэг өөрийн гэсэн хувийн орон зайгүй
- Өөр бусад үйлчлүүлэгч нартай эсхүл ганцаар хүн амьдрахад тохиромжгүй, хэт давчуу орон зайд амьдрах
- Ажил олгогчийн зөвшөөрөлгүйгээр гадагшаа гарах боломжгүй, эсхүл хязгаарлагдмал орон зайд гадагш гарах боломжтой нөхцөлд байх
- Хоол хүнсний үлдэгдлээр хооллох эсхүл чанар нь хэт муу бүтээгдэхүүнээр хооллох
- Хөдөлмөрийн хөлсөө авч чадахгүй байх
- Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй байх
- Хэт олон цагаар ажиллах
- Дарамтлах, заналхийлэх, хүчирхийлэх зэрэг болно.

Хэрэв дээрх шинж тэмдэг илэрч мэдэгдсэн эсхүл хохирогч ийм шинж тэмдэгтэй байгаа тухай мэдээллэсэн бол даруй асуумжийн дагуу ярилцлагыг явуулж, дараагийн шатны арга хэмжээ авах нь чухал юм. Учир нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд, захиалагч, зуучлагч, ажил олгогчид нь хохирогчийн сэтгэл зүй болон бие махбодыг бүрэн хяналтандаа авахын тулд байнга дарамтлах, айлган сүрдүүлэх, хүчирхийлэх үйлдлүүдийг гаргадаг. Тухайлбал³⁰:

- Хүч хэрэглэх-хохирогчийг эрхшээлдээ оруулахдаа бусад хохирогчийн дэргэд хүч хэрэглэх, хэрцгийгээр зодох, тарчлаадаг. Энэ нь бусад хохирогч үг дуугүй хэлснийг нь дагах нөхцлийг бүрдүүлдэг.

30 Хамтын бүтээл, Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага /хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг/, УБ.,2019

- Айлган сүрдүүлэх-байнгын айдаст байлгах, өөрийг нь болон гэр бүлийн гишүүдийг нь заналхийлэх, сүрдүүлдэг.
- Хууран мэхлэх-хохирогчийг өөртөө итгэх итгэл, эргэн тойрноо ойлгох ойлголтгүй болгох, байнгын найдвар төрүүлэх, өөрөөс нь өөр хэн ч тусалж, хамгаалж чадахгүй гэсэн ойлголтыг бий болгодог.
- Урьдчилан таамаглах боломжгүй нөхцлийг бий болгох-хохирогчийг тогтворгүй болгох, ямарваа зүйлийг төлөвлөх боломжийг хаах эсвэл тэдний ертөнцийг үзэх үзэл, амьдралын хэв маягийг өөрчилж зөвхөн хариу өгөх, өөрийгөө хамгаалж амь гарах арга барилтай болгох, хайр сэтгэлтэй дүр үзүүлдэг.
- Шийдвэр гаргах эрх мэдэлгүй болгох-хүний сайн сайхан байдал, амь гарах эсэх нь “эзэн”-ээс шалтгаална, “эзэн”-ий үгэнд орж түүнийг сэтгэл хангалуун байхаас шалтгаална гэсэн ойлголтыг төрүүлэх, буруу алхам хийвэл одоо байгаагаасаа нөхцөл байдал дордоно гэж итгүүлдэг.
- Сэтгэл хөдлөлийг нь хянах-гэмт үйлдлийнхээ эерэг талуудыг харуулахыг оролдох ба хохирогчид хийж буй ажил нь гэр бүлдээ туслах боломж гэсэн ойлголт төрүүлэх, мөрөөдлөө биелүүлэхэд тусалж, ирээдүйд илүү сайхан амьдарна гэсэн тэдний хүлээлтийг бий болгодог.
- Хуулийн байгууллага, цагаачлалын албаар сүрдүүлэх-хэрэв оргох, эсэргүүцэх байдал үүсгэвэл хууль, хяналтын байгууллагад хандсанаар энд байгаагаас илүү аймшигтай нөхцөлд орно, хуулийн байгууллага бидний талд ажилладаг, танил тал ихтэй гэж итгүүлдэг.
- Мансуурах бодис хэрэглүүлэх-архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэлийг хүчээр хэрэглүүлдэг.
- Эрүүл мэндийн эрсдэлд оруулах-үйлчлүүлэгч хүсвэл хамгаалалтгүй бэлгийн харьцаанд оруулах, сарын тэмдэгийг хүчээр зогсоох, жирэмслэлтийг хүчээр зогсоох, ураг зулбуулах, бэлгийн болон бусад халдварт өвчтэй болгодог.

Хүчирхийллийн эдгээр олон аргуудыг хэрэглэж байгаагийн гол зорилго нь хохирогчийг өөрөөсөө хамааралтай болгож, бие хүн гэсэн сэтгэлгээг устгаж, хэн ч надад тусалж чадахгүй, энэ хүн л надад тусална, өөр гарц байхгүй гэсэн сэтгэлгээг суулгаснаар бусадтай харилцах холбоог үгүй болгодог.

Иймээс хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх, холбон зуучлах үйлчилгээнд хамруулах зэрэг анхан шатны нэгжид ажиллаж буй нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд заавар, зөвлөмж болгох зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 тушаалаар Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх зааврыг баталсан байна. Анхан шатны нэгж болох баг, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй хүн, хүүхдийг дараах асуумжийг ашиглан тогтооно.

Хүснэгт 2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж илрүүлэх асуумжийн маягт


№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
	Нас:			
	Хүйс:			
	Суралцаж буй байдал:			
	Амьдралын нөхцөл байдал:			
Асуумж				
1	Хүүхэд гэр бүлээсээ тусдаа амьдарч байна уу?			
2	Хүүхэд хүссэн үедээ эцэг эхтэйгээ уулзах боломжгүй байна уу?			
3	Хүүхэд сургуульд явахаа больсон уу?			
4	Хүүхдийн зан авирт огцом өөрчлөлт гарсан шинж ажиглагдсан уу?			
5	Хүүхэд бэлгийн мөлжлөгт өртсөн байх магадлалтай талаар мэдээлэл авсан уу?			
6	Хүүхэд өөрөө бэлгийн мөлжлөгт өртсөн талаар мэдээлэл өгсөн үү?			
7	Хүүхэд хөдөлмөр мөлжлөгт өртсөн байх магадлалтай талаар мэдээлэл авсан уу?			
8	Хүүхэд өөрөө хөдөлмөр мөлжлөгт өртсөн талаар мэдээлэл өгсөн үү?			
9	Хүүхэд хэт урт цагаар, амралтгүйгээр ажилладаг уу?			
10	Хүүхдийн яриа эмх цэгцгүй, эргэлзсэн эсвэл сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл, сэтгэцийн хувьд хэвийн биш байгаа байдал харагдаж байна уу?			
11	Хүүхдэд бие махбодын хүчирхийллийн шинж тэмдэг илэрч байна уу?			
12	Хүүхэд ажлын байран дээр хоног төөрүүлдэг, ажлын байрандаа амьдардаг			
13	Хүүхэд аймхай, цочимхой, хүлцэнгүй, бусдаас хараат шинж байна уу?			
14	Хүүхдэд хоол хүнс, амралт, нойр, эмнэлгийн тусламж дутагдсан шинж тэмдэг илэрч байна уу?			
15	Хүүхэд ихэвчлэн өөрийг нь хянадаг эсвэл нөхцөл байдлыг байнга хянаж байгаагаа илэрхийлдэг хэн нэгэнтэй хамт байдаг уу? (хаашаа явах, хэнтэй уулзах, ярилцах, асуултад юу гэж хариулах талаар байнга заадаг, хянаж шалгадаг гм)			
16	Хүүхдэд юу хэлэхийг зааж сургасан шинж ажиглагдаж байна уу?			
17	Хүүхэд хэвийн амьдрахад тохиромжгүй нөхцөлд амьдарч байна уу?			
18	Хүүхэд өмнө нь гэмт хэрэг, ялангуяа бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн хохирогч болж байсан уу?			
19	Тухайн хүүхэд амьдарч буй газраа чөлөөтэй орхиж чадах уу?			

20	Тухайн хүүхдэд улирлын чанартай хувцас дутагдсан, эсвэл насандаа тохирохгүй илт бэлгийн болон хөдөлмөр мөлжлөгт өртөж буйг илтгэх хувцас, хэрэгсэлтэй байна уу?			
21	Хүүхэд хийсэн ажлынхаа хөлсийг тохиролцсон хэмжээндээ авч чадсан уу?			
22	Хүүхдийн хөдөлмөр эрхэлсэн хөлсийг хэн нэгэн шууд болон шууд бусаар авдаг байсан уу? (эцэг эх, гэр бүл, хамаатан садан, ажил олгогч гм)			
23	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах яаралтай үндэслэл байна уу?			
24	Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бусад хүчин зүйл байгаа юу?			
25	Ямар нэгэн хүчирхийллийн улмаас гэрээсээ зугатааж, оргож байсан уу?			
26	Цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлагдаж байсан уу? (хэдэн удаа)			
27	Хүүхэд амиа хорлох, биеэ гэмтээх оролдлого хийж байсан уу?			
28	Цагдаагийн байгууллагад зөрчлийн улмаас саатуулагдаж байсан уу?			
Тэмдэглэл:				

Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь дээрх асуумжийн дагуу ярилцлагыг явуулахдаа хүүхдийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорино. Ярилцлагын явцад дараах зөвлөмжийг мөрдлөгө болгох нь хохирогчийн сэтгэл зүйн дарамт стрессийг нэмэгдүүлэх, болж өнгөрсөн үйл явдлыг дахин ярихаа болих, цаашилбал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад үнэн зөв мэдээлэл өгөхөөс цааргалах нөхцөл байдлыг бий болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

- Ярилцлагын явцад хохирогч төвтэй хандлагатай, хүүхдийн эрхийн мэдрэмжтэй байж, асуумжуудыг хүүхдэд аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлан өгч, тодорхой хариулт авахыг зорих;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй хүүхдийг сэтгэл зүйн дарамтанд орох эрсдлээс сэргийлэх, болж өнгөрсөн үйл явдал, гэмт хэргийн нөхцөл байдлын талаар олон удаагийн давтамжтай яриулахаас татгалзах;
- Ярилцлагын явцад хүн худалдаалах хэргийн хохирогч, мөлжлөгт өртөгч, биеэ үнэлэгч гэх мэт үгсийг ашиглахгүй байх;
- Зөвлөгөө авагчийн асуултад хариулж буй байдал логик холбоотой байгаа эсэхэд анхаарлаа хандуулж, эргэлзээтэй санагдсан хариултыг 4-5 асуулт, хариулт явуулсны дараа дахин тодруулан асууж нягтлах;
- Хохирогч асуумжийн хэдэн хариултыг ТИЙМ гэж хариулт өгч байгаад анализ хийж, 10 буюу түүнээс дээш асуултанд “Тийм” гэсэн хариултыг өгч байвал ХХГХ-ийн хохирогч болсон байх магадлалтай гэж үзэж, дараагийн арга хэмжээг түргэн шуурхай авах зэрэг болно.

Зураг 3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй хүүхдийг холбон зуучлах зураглал



Ярилцлагын явцад илэрсэн хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай өөр бусад хүмүүсийн талаарх мэдээлэл илэрвэл тэр талаар тэмдэглэлд тодорхой тусган авч, нэн даруй цагдаагийн байгууллагад мэдээлэх хэрэгтэй. Нийгмийн ажилтан болон хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нь тухайн хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байх магадлалтай гэх үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хандаж, шуурхай арга хэмжээг авна.

Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулахаар мэргэжлийн, дагнасан үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагад шилжүүлнэ.

Анхан шатны нэгжээс холбон зуучлах үйлчилгээгээр хүлээн авсан хүүхдийг хохирогч мөн эсэхийг үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас дахин шалгаж болох бөгөөд энэ тохиолдолд дээрх асууж болон Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS6418:2013 стандартын I хавсралтаар баталсан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох жишиг маягтын дагуу асуумж авна. Энэ тохиолдолд хохирогч хүүхдийг сэтгэл санааны хямралд орох, дарамтанд орох, стресс бухимдалд автуулахгүй байхад анхаарна.

Хүснэгт 3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох нийтлэг асуулт

Нэг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох нийтлэг асуулт	
1	Энэ ажлыг хэн, хаанаас, ямар байдлаар санал болгосон бэ?
2	Тухайн ажиллах газарт ирүүлэхээр хэн нэгэн: – Хүч хэрэглэсэн үү? – Хүч хэрэглэхээр заналхийлсэн үү? – Эсхүл хулгайлсан үү? – Эсхүл хууран мэхэлсэн үү? – Эсхүл ойр дотны болон албан үүргийн хувьд холбоотой хүмүүс нь аливаа хэлбэрээр нөлөөлсөн байх магадлал бий юу?

3	Тухайн ажлыг хийлгэхээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх зэрэг ямар нэгэн гэрээ хийсэн үү?	
4	Санал болгосноосоо өөр ажил хийхийг албадаж хийлгэсэн үү? Тийм бол ямар ажил хийхийг, ямар хэлбэрээр албадсан бэ?	
5	Ажлын хөлсөнд бэлэн мөнгө өгч байсан уу? Тийм бол ямар хэмжээний? Санал болгож байснаасаа зөрүүтэй юу?	
6	Ажил олгогч болон ажил санал болносон хүндээ өртэй юу? Тийм бол өр яаж үүссэн, үүнийг нотлох гэрээ болон бусад баримт хийж байсан үү?	
7	Ажиллаж, амьдарч буй орчноосоо гадагш гарч чадаж байсан үү? Тийм бол ямар хэмжээнд	
8	Олон нийтийн газраар явдаг байсан уу? Тийм бол хяналт тавьдаг байсан үү? Яаж?	
9	Орговол өөрт нь болон гэр бүл, ойр дотны хүмүүст нь хохирол учруулахаар заналхийлдэг байсан үү?	
10	Ямар нэгэн хүчирхийлэлд өртөж байсан үү? Тийм бол ямар?	
11	Мэдээлэл, харилцаа холбооны хэрэгсэл хэрэглэх боломж байсан үү? Тийм бол ямар?	
12	Ажиллаж, амьдарч байсан нөхцөл ямар байсан бэ? Ямар нөхцөлд унтаж, хооллож байсан бэ?	
13	Хоол хүнсгүй байх, эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй, амралтгүй ажиллах тохиолдол гарч байсан үү? Тийм бол ямар хэмжээнд	
14	Өдөрт хэдэн цаг ажилладаг байсан бэ?	
Хоёр. Хил дамнуулан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох нэмэлт онцлог асуулт		
1	Гадаад улсад ажиллахдаа ямар зорилготой байсан бэ?	
2	Гадаад улсад зорчих бичиг баримтыг хэн бүрдүүлсэн бэ?	
3	Гадаадын өөр орноор дамжсан үү?	
4	Гадаадад зорчих бичиг баримтын болон аяллын зардлыг өөрөө төлсөн үү? Үгүй бол хэн, ямар хэмжээний төлбөрийг, ямар нөхцөлтэйгөөр төлсөн бэ?	
5	Ямар боомтоор хил гарсан бэ?	
6	Гадаад паспорт болон бусад хувийн бичиг баримт нь өөрт нь байгаа юу? Үгүй бол яагаад?	
7	Гадаад паспорт болон бусад бичиг баримт хуурамчаар авч байсан үү?	

!!! Дээрх асуумж нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг тодорхойлох зорилготой асуумж бөгөөд насны хувьд ямар нэгэн ялгаварлалгүй тавигдах асуумжтай тул хүүхдийг энэ асуумжийн дагуу асууж, хохирогч мөн биш эсэхийг тогтоох нь учир дутагдалтай байж болох юм.

Анхан шатны нэгжид ажиллаж буй нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс гадна эмч, эмнэлгийн ажилтан, цагдаагийн хэсгийн байцаагч нар мөн энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон хүн, хүүхдийг илрүүлэхэд оролцох нь зүйн хэрэг юм.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтнүүд дараах асуумжийн дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч буй хүнээс мэдээлэл цуглуулах замаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн эсэхийг тодорхойлж болно³¹.

Хүснэгт 4. Эрүүл мэндийн ажилтны хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх асуумж

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1	Нас:			
2	Хүйс:			
Асуумж				
3	Таны биед ямар нэгэн зовиур байна уу?			
	Хэрэв байгаа бол таны биеийн аль хэсэгт зовиур байна вэ?			
	Энэ зовиур хэзээнээс бий болсон бэ?			
4	Таны биед үүссэн гэмтэл, шарх, сорви /сонгох/ хэзээ, юунаас болж үүссэн бэ?			
	Яагаад ийм гэмтэл, шарх, сорвитой болсон бэ?			
5	Танд хэн нэгний зүгээс хүчирхийлэл, дарамт, шахалт ирж байсан уу?			
	Өмнө нь хүчирхийлэл, дарамт, шахалтанд орж байсан уу?			
	Хэрэв орж байсан бол цаг хугацааны хувьд хэзээ ийм зүйл тохиолдсон бэ?			
6	Танд цаашид ямар нэгэн тусламж, дэмжлэг хэрэгтэй байна уу?			
Тэмдэглэл:				

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь дан ганц бэлгийн мөлжлөгт өртөхгүй бөгөөд хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтний наймаа, гуйланчлал зэрэг төрөл бүрийн хэлбэрээр өртсөн байна. Иймд эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчид дээрх асуумжид дурдсан шинж тэмдэг байгаа бол түүнийг тодруулах, биед нь учирсан гэмтэл, шарх, сорви хэзээ, хэрхэн үүссэн, хэн үүсгэсэн, хэн нэгэн хүн, бүлэг этгээдийн эрхшээлд байгаа эсэхийг харилцан яриа, биеийн байдал, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр тодруулахыг зорино. Ингэхдээ дараах зөвлөмжийг дагахыг зөвлөж байна.

- Ярилцлагыг явуулахдаа хохирогч төвтэй хандлагатай, хүний болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих,
- Болж өнгөрсөн үйл явдал, гэмт хэргийн нөхцөл байдлын талаар олон дахин яриулахгүй байхыг эрмэлзэх,
- Ярилцлагын явцад хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг ашиглахгүй байх хэрэгтэй.


Эмнэлгийн мэргэжилтэн нь тухайн үйлчлүүлэгчээ хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж магадгүй гэх үндэслэл байвал цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж, дараагийн шатны арга хэмжээг авахуулах учиртай.

31 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрхийнтөв ТББ, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх гарын авлага, УБ.,2022

1.2

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ БА ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАХ АЖИЛЛАГАА

Гэмт явдалтай тэмцэх зорилтыг амжилттай шийдвэрлэх нь эрүүгийн хэргийг хуулийн дагуу цаг алдалгүй шалгахаас ихээхэн шалтгаалдаг. Тийм ч учраас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэж байгаа мөрдөн шалгах ажиллагааны анхдагч үе шат нь аливаа гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах процесс юм.



Зураг 4. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх ажиллагааны зураглал

Анхан шатны нэгжийн нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон эмнэлгийн мэргэжилтнээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй хүний мэдээлэл болон асуумж, бусад холбогдох бичиг баримтыг цагдаагийн байгууллагад шилжүүлнэ. Өөрөөр хэлбэл дээрх албан хаагч нар нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь хэсэгт заасан “гэмт хэрэг, зөрчлийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх” үүргээ биелүүлж байна гэсэн үг юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын талаар авч үзсэн.

Зураг 5. Хүн худалдаалах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага



Тагнуулын байгууллага нь өөрийн илрүүлсэн хүн худалдаалах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй³² бол цагдаагийн байгууллага энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг заавал хүлээн авч шалгах үүрэг хүлээж байна. Иймээс анхан шатны нэгжээс хуульд заасан үндэслэл, журмын дагуу шилжүүлэн ирүүлсэн материалыг цагдаагийн байгууллага хүлээн авч шалгах нь эндээс харагдаж байна.

Цагдаагийн байгууллагаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан дараах үндэслэл байвал гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажиллагааг явуулна. Үүнд:

- хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэргийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн;
- гэмт хэргийн шинжийг өөрөө шууд илрүүлсэн;
- гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирсэн.

Дээрх үндэслэлийн аль нэг нь байвал мөрдөгч, прокурор гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хүлээн авах үүрэг хүлээнэ.

Нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эмнэлгийн мэргэжилтнээс ирүүлсэн мэдээллийг гэмт хэргийн талаарх мэдээллэсэн үндэслэлээр хүлээн авч, шалгана.

Анхаарах!!! Гэмт хэргийн талаарх гомдол гаргасан эсхүл мэдээлэл өгсөн хүнд санаатайгаар худал мэдээллэвэл Зөрчлийн тухай хууль³³-д заасан хариуцлага хүлээлгэх талаар сануулна.

32 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, 6.1 дүгээр зүйлийн 6.1.1.2 дахь хэсэг

33 15.9 дүгээр зүйл.Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх

15.9.1. Гэмт хэрэг, зөрчил, түргэн тусламж, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймрийн талаар эрх бүхий байгууллагад хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй үндэслэлээр өмнөх бүлэгт авч үзсэн шалгах хуудасны дагуу асуумж авч, эрсдэлтэй нөхцөлд байгаа гэдгийг тодруулсан анхан шатны нэгжид ажиллаж буй мэргэжилтэн энэ гэмт хэргийн талаарх мэдээллийг харьяалал харгалзахгүй цагдаагийн аль нэг байгууллагад дараах хэлбэрээр гаргана.



Биечлэн



Харилцаа холбооны хэрэгслээр



Бичгээр

Хэрэв гаргасан мэдээллийг хүлээн авах болон хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.1 дүгээр зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй”, 15.7 дугаар зүйлд “оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана” гэж заасны дагуу гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй байна.

Мөрдөгч хүүхдийн эсрэг үйлдсэн хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан бол гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тодруулах зорилгоор дараах ажиллагааг явуулна³⁴.

Зураг 6. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны зураглал



Үзлэг хийх: Гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт хийж буй мөрдөн шалгах ажиллагааг үзлэг хийнэ.

Зураг 7. Үзлэг хийж болох объектууд



хүний бие



эд зүйл



бичиг баримт



тээврийн хэрэгсэл



ачаа тээш



мал амьтан



гэмт хэрэг үйлдэгдсэн газар

34 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, 30.7 дугаар зүйл

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан мөрдөгч нь нөхцөл байдлыг харгалзан үзсний үндсэн дээр үзлэгийн аль төрлийг явуулах асуудлыг шийдвэрлэх бөгөөд үзлэгийг явуулахдаа ЭХХШТХ-ийн 23.1, 23.2, 23.3 дахь хэсэгт заасан үндэслэл, журмыг баримтална³⁵.

Анхан шатны нэгжээс ирүүлсэн асуумж болон холбогдох бусад бичиг баримт эсхүл хохирогчийн биед учирсан гэмтэл, шарх, сорви, бусад эд зүйлд үзлэг хийх процесс явагдах тул нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан болон эмнэлэгийн мэргэжилтэн шаардлагатай бичиг баримт, бусад эд зүйлийг аль болох асуумжид хавсаргах, хавсаргах боломжгүй бол байгаа газрыг тодорхойлох зэрэг өөрийн хэмжээнд устах, гэмтэхээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээ авах нь чухал юм.

Шинжээч томилох, шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай болсон тохиолдолд шүүгч, прокурор, мөрдөгч тусгай мэдлэг эзэмшсэн этгээдийг шинжээчээр томилж, дүгнэлт гаргуулна. Шинжээч гэдэг нь шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийг хэлнэ³⁶.

Дараах тохиолдолд шинжилгээг заавал хийлгэнэ. Үүнд:

- гадны нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;
- хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шинж байдлыг тогтоох;
- гэрч³⁷, хохирогч³⁸, сэжигтэн³⁹, яллагдагч⁴⁰, шүүгдэгч⁴¹ хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл түүний сэтгэцийн байдлыг тодорхойлох;
- бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох;
- сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн насны тухай бичиг баримт байхгүй бөгөөд тэдний насыг тогтоох нь хэрэгт ач холбогдолтой байвал.

Шинжилгээ гэдэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа тусгай мэдлэг шаардсан асуудлыг шийдвэрлэхийн тулд тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийн тусламжтайгаар, мөрдөгч, прокурор, шүүгчийн шийдвэрээр явуулж буй мөрдөн шалгах ажиллагааг хэлнэ⁴².

35 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 23.1 дүгээр зүйл. Үзлэг хийх

1. Мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийнэ.

23.2 дугаар зүйл. Хүний биед үзлэг хийх

1. Хүний биед хэргийн үл мөр, онцлог шинж тэмдэг байгаа, эсхүл хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг тухайн хүн биедээ авч яваа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол түүнийг илрүүлэх зорилгоор хүний биед үзлэг хийнэ.

23.3 дугаар зүйл. Хэргийн газрын үзлэг

1. Мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй гэх бодит үндэслэл байгаа бол хэргийн нотлох баримтыг олж тогтоох, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор орон байр, бусад газар, нийтийн эзэмшил газрын тодорхой хэсгийг хэргийн газраар тогтоон үзлэг хийнэ.

36 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2017, 27.1 дүгээр зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2009, 6 дугаар зүйл

37 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.

38 Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.

39 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ.

40 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ.

41 Шүүхээр хянан хэлэлцэж байгаа хэргийн оролцогч-яллагдагчийг шүүгдэгч гэнэ.

42 Мөн тэнд

Гомдол, мэдээллийг хүлээн авмагц түүнд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тодруулах зорилгоор хүний бие, цогцос, түүний эд эрхтэн, мал, амьтан, эд зүйл, баримт бичгээс хэв загвар, дээж авна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүн, хүүхдийн биед ямар нэгэн гэмтэл бэртэл, шарх сорви үүссэн байвал гэмтлийн зэргийн, эсхүл биед байсан болон бусад бичиг баримтад шаардлагатай тохиолдолд баримт бичгийн шинжилгээ хийнэ. Гэхдээ шинжилгээ хийлгэх нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй болохыг анхаарах хэрэгтэй.

Хохирогч, гэрчээс мэдүүлэг авах

Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагаар хохирогч болон гэрчээс ЭХХШТХ-ийн 25.1 дүгээр зүйлд заасан үндэслэлээр мэдүүлэг авна.

Өөрөөр хэлбэл хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүнээс болон энэ талаар цагдаагийн байгууллагад мэдээлэл өгсөн хүнээс нөхцөл байдлыг тодруулах, гэмт хэргийг илрүүлэх, шаардлагатай нотлох баримтуудыг цуглуулахад шаардлагатай мэдээллийг авах зорилгоор мэдүүлэг авна.

<p>МЭДҮҮЛЭГ АВАХ НИЙТЛЭГ ЖУРАМ</p>	<p>Мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна. Шаардлагатай бол мэдүүлгийг тухайн хүний байгаа газарт очиж авч болно.</p> <p>Хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа тусгайлан бэлтгэсэн өрөө эсхүл хүүхдийн байгаа газарт нь очиж мэдүүлэг авах, цагдаагийн албан хаагч мэдүүлэг авахаар очихдоо албаны дүрэмт хувцас өмсөхгүйгээр очих зэрэг сайн туршлага бий.</p> <p>Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг цагдаагийн байгууллагад авчрахгүйгээр байгаа газарт нь очиж мэдүүлэг авах, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагад байгуулсан хүүхдээс мэдүүлэг авах өрөөнд очиж мэдүүлэг авч болох юм.</p>
	<p>Мэдүүлэг авах хүмүүсийг тус тусад нь байлгаж мэдүүлэг авах ба мөрдөгч нэг хэрэгт мэдүүлэг авах хүмүүсийг өөр хоорондоо харилцахгүй байх арга хэмжээ авна.</p>
	<p>Мөрдөгч мэдүүлгийн эхэнд тухайн хүний хувийн бичиг баримтыг шалгаж, түүнд ямар зорилгоор мэдүүлэг авахаар хэзээ, хэн гэдэг прокурорын шийдвэрээр дуудан ирүүлсэн, түүнчлэн энэ хуульд заасан эрх, үүргийг нь танилцуулсан тухай тэмдэглэлд тусгана.</p>
	<p>Мөрдөгч мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна.</p>
	<p>Мэдүүлэг өгөх хүн баримт бичиг, бичлэг ашиглаж болно. Мэдүүлэг өгөхөд ашигласан зүйл, тухайн хүний үйлдсэн зураглал, хүснэгт, зургийг бүрэн эхээр нь, эсхүл хуулбарыг нь тэмдэглэлд хавсаргаж болох ба энэ тухай тэмдэглэлд тусгана.</p>
	<p>Мэдүүлэг авсны дараа дахин мэдүүлэг авах үед өмнөх мэдүүлэгтэй нь холбогдуулан мөрдөгч эд мөрийн баримт, баримт бичиг, бусад нотлох баримтыг мэдүүлэг өгч байгаа хүнд үзүүлж, бусад мэдүүлгийн тэмдэглэлийг танилцуулж болох ба энэ талаар тэмдэглэлд тусгана.</p>

Мэдүүлгийн явцад орчуулагч, хэлмэрч оролцуулах шаардлагатай бол тэдэнд эрх, үүргийг тайлбарлан өгч, санаатайгаар худал орчуулах, эсхүл хэлмэрчилбэл Эрүүгийн хуулийн 21.3 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага⁴³ хүлээлгэх талаар сануулж, баталгаа авч, гарын үсэг зуруулна.

⁴³ Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2015, 21.3 дугаар зүйл
 1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд, эсхүл Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд үнэн зөв орчуулах, хэлмэрчлэхээ илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал орчуулсан, хэлмэрчилсэн бол гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

Гэрч, хохирогч нь хэл яриа, сонсголын бэрхшээлтэй бөгөөд тухайн тохиолдолд хэлмэрчийг оролцуулах боломжгүй бол түүний зөвшөөрснөөр бичгээр асуулт тавьж, хариулт авах байдлаар мэдүүлэг авч болно.

Зураг 8. Мэдүүлэг авах ажиллагааны хугацаа



Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд болон насанд хүрээгүй гэрчээс ЭХХШТХ-ийн 25.3 дугаар зүйлд заасан журмаар мэдүүлэг авна.



Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлана.

Арван зургаан насанд хүрээгүй гэрч, хохирогчид санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахгүй.

Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана

Мэдүүлэг авахад оролцож байгаа хүн арван найман насанд хүрээгүй гэрчид асуулт тавьж болно.

Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа⁴⁴:

- Ихэнх хохирогч шууд хууль сахиулах байгууллагад хандаагүй байдаг нь тэдний хууль сахиулах байгууллагад итгэх итгэлтэй холбоотой. Иймээс тэдний энэ айдас, итгэлгүй байдлыг санаж мэдүүлэг авах ажиллагааг төлөвлөх, бэлтгэх;
- Насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авахдаа албаны дүрэмт хувцасыг өмсөхгүй байх нь тэдний сэтгэл санааны байдалд сайнаар нөлөөлдөгийг санах;
- Мэдүүлгийг авахдаа аль болох энгийн, ойлгомжтой, хоёрдмол утгагүй үг ашиглах, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, биеэ үнэлэлт зэрэг нэр томьёог аль болох ашиглахгүй байх;
- Болж өнгөрсөн үйл явдлын талаар удаа дараа яриулахгүй байхад анхаарах мэдүүлгийг анхны удаа авахдаа шаардлагатай бүх мэдээллийг цуглуулахуйц явуулахад анхаарах хэрэгтэй юм.

44 НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хүн худалдаалахын хохирогчийг илрүүлэх, ярилцлага авах болон тусламж үйлчилгээнд хамруулах тухай заавар, УБ.,2017

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлд өмгөөлөгч заавал оролцох дараах тохиолдлуудыг хуульчилсан бөгөөд энэ нь зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хамааралтай байхаар зохицуулагдсан. Үүнд:

- хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй;
- өсвөр насны;
- монгол хэл, бичиг мэдэхгүй;
- бүх насаар хорих ял оногдуулж болох;
- хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
- төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан зэрэг болно.


Хэдийгээр өмгөөлөгч заавал оролцох тохиолдол нь хохирогчид хамааралгүй боловч хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч болсон насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авахдаа заавал өмгөөлөгч оролцуулахыг зөвлөж байна.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлд зааснаар арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулах бөгөөд тухайн этгээд нь байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтооно.

Ийнхүү томилогдсон хууль ёсны төлөөлөгч нь хохирогчийн эрх, үүргийг эдлэх бөгөөд хамгийн гол нь насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хамгааллын үйлчилгээг хууль, журам, стандартад заасны дагуу үзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай, шударга, хууль ёсны дагуу явагдахад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд дээд шатны байгууллага албан тушаалтанд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх хэрэгтэй.

Зураг 9. Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахад хориглох зүйлс

Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа өмнө дурдсан хориглох зохицуулалтаас гадна		
		
Мэдүүлэг авахад оролцож буй хүн насанд хүрээгүй хохирогчид асуулт тавихыг хориглоно	Арван найман насанд хүрээгүй хүний эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл байвал хууль ёсны төлөөлөгч, төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулахгүй	Шөнийн буюу 22-06 цагийн хооронд мэдүүлэг авахгүй



Гэхдээ хүүхдээс мэдүүлэг авах тохиолдолд 2 цагаас хэтрүүлэхгүй байх ёстойг анхаарах!!!

Хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах, эд хөрөнгө битүүмжлэх

Гэмт хэргийн шинжийг тодруулахад ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, бусад эд зүйлс байна гэж үзэх хангалттай үндэслэл тогтоогдвол мөрдөгч прокурорын зөвшөөрлөөр түр хураан авна.

- Төрийн нууц агуулсан эд мөрийн баримтыг зохих байгууллагын удирдлагад мэдэгдсэний үндсэн дээр;
- Шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг шуудан-цахилгаан харилцааны байгууллагад байх үед нь прокурорын зөвшөөрлөөр;
- Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйлийг хураан авахад мэргэжилтнийг оролцуулж;
- Хэрэгт ач холбогдолтой цахим баримтыг хуулбарлан авах, эсхүл түүнийг устгах, нэвтрэх боломжийг хязгаарлах боломжгүй бол цахим төхөөрөмжийг;
- Тэсэрч дэлбэрэх, хордуулах бодисыг хураан авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах, эсхүл мэргэжлийн байгууллагад хандан гүйцэтгүүлж тус тус хураан авна.

Харин гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжлэх ажиллагааг явуулна.

1.3

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДСЭН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ НОТЛОГДВОЛ ЗОХИХ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхийн тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн шалган тогтоох шаардлагатайг хуульчлан өгсөн байдаг.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд мөрдөн шалгах ажиллагааны гол цөм болсон эрүүгийн хэргийн нотлох ажиллагаа чухал үүрэгтэй. Гэмт хэргийн нотлох ажиллагаа нь дараах шинжтэй бөгөөд аль нэг шинж нь алдагдвал нотлох ажиллагааг хууль бусаар явуулсанд тооцогдох эрсдэлтэй байна. Үүнд:

1. Танин мэдэх болон объектив үнэнийг сэргээн тогтооход чиглэгдэх;
2. Нотлох ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах;
3. Нотлох ажиллагааг зөвхөн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий этгээдээс хэрэгжүүлэх;
4. Эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг албан ёсны нотлох баримтын тусламжтайгаар тогтоох.

Хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоож, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн тулд дараах асуудлуудыг нотолсон байх хуулийн шаардлагатай. Үүнд:



Гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал/;

Гэмт хэргийг хэн үйлдсэн;

Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;

Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;

Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Гэмт хэрэг гарсан байдал

Эрүүгийн хэрэг нэг бүрт гэмт хэрэг гарсан болон уг гэмт хэрэг хэрхэн үйлдэгдсэн буюу гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, газар, арга зэргийг нотлох ажиллагааны тусламжтайгаар тогтооно. Өөрөөр хэлбэл тусгай зорилгоор хүнийг худалдаалахдаа хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хяналтандаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдах аргаар хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан идэвхтэй үйлдлийг тогтооно гэсэн үг юм.



Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

Хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь эдгээр үйлдлүүдийн аль нэгийг хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг бөгөөд үйлдлийн аргуудыг тайлбарлавал⁴⁵:

- “Хүч хэрэглэсэн” гэж гэмт этгээд хохирогчийн бие махбодид халдаж, түүний эсэргүүцлийг няцаасан байхыг ойлгоно. Хохирогчийн бие махбодид халдах үйлдэл нь алгадах, цохих, түлхэх, дарах, хоолойг боох, зэрэг хэлбэртэй байж болно.
- “Хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар үйлдсэн” гэж гэмт этгээд хохирогчийг болон ойр дотны хүнийг ална, эрүүл мэндэд хохирол учруулна, эрх, эрх чөлөөг хязгаарлана зэргээр айлан сүрдүүлсэн байхыг ойлгоно.
- “Хулгайлсан” гэж хүнийг худалдаалах зорилгоор Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдэл хийхийг ойлгоно.
- “Хууран мэхэлсэн” гэж үгээр буюу үйлдлээр бодит байдлыг нуун дарагдуулах эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлснийг ойлгоно. Тухайлбал хохирогчийг гадаад улсад өндөр цалинтай ажилд зуучилна, суралцуулна, тэтгэлэг олгуулна, виз гаргана зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ.
- “Итгэл эвдсэн” гэж хоёр талын итгэлцэлд үндэслэх бөгөөд хохирогчид ашигтай нөхцөл бий болгоно гэж хуурамч гэрээ бичиг баримт ашиглан итгүүлэх, дараа нь итгэлийг нь хөсөрдүүлснийг ойлгоно.
- “Эрх мэдлээ урвуулан ашигласан” гэж албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж үйлдсэнийг ойлгоно.
- “Хохирогчийн эмзэг байдлыг далимдуулсан” гэж хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин түүнчлэн, амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.
- Хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулсан

45 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги, УБ.,2019

гэж хохирогчийг бүх хэлбэрээр хяналтдаа байлгаж буй этгээд өөртөө эдийн болон эдийн бус ашигтай байдлыг бий болгох болзолтойгоор бусдад хүнийг шилжүүлж буй үйлдлийг ойлгоно. Тухайлбал өөрийн асрамжид байдаг бага насны хүүхдийг бусдаас мөнгө авч, шилжүүлсэн г.м

- “Элсүүлсэн” гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болго аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.
- “Тээвэрлэсэн” гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй этгээдийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно. Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.
- “Дамжуулсан” гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ.
- “Орогнуулсан” гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.
- “Хүлээн авсан” гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.



Шигтгээ 1

Шүүгдэгч А.Б нь гэмт хэргийн хохирогч болох үедээ 15 нас 10 сартай байсан насанд хүрээгүй хохирогч Б.Х-г 2018 оны 05 дугаар сарын сүүлээс 2018 оны 06 дугаар сарын 22-ныг хүртэл хугацаанд, гэмт хэргийн хохирогч болох үедээ 16 нас 10 сар 10 хоногтой байсан насанд хүрээгүй хохирогч С.М-г 2018 оны 06 дугаар сарын 17-ноос 22-ны өдрийн хооронд биеийг нь үнэлүүлэх зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж, эмзэг байдлыг нь далимдуулж эрхшээлдээ оруулан элсүүлэн, тээвэрлэсэн, орогнуулсан, хүүхэд гэдгийг нь мэдсээр байж, хоёр түүнээс олон хүнийг олон хүнийг худалдаалсан гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар тогтоогдсон тул гэм буруутайд тооцож, долоон жилийн хорих ялаар шийтгэжээ.

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 1034 дугаартай шийтгэх тогтоолоос⁴⁶

Дээрх тохиолдолд хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эдийн засгийн эмзэг байдлыг нь ашигласан, эрхшээлдээ оруулсан, орогнуулсан зэрэг идэвхитэй үйлдлийг гаргасан байна.

Гэмт хэргийг үйлдсэн этгээд

Энэ нь тухайн гэмт хэргийг тодорхой ямар хүн, хуулийн этгээдээс үйлдсэн тухай ойлголт буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын асуудал юм. Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект гэдэг нь хамгийн өргөн утгаар тодорхойлбол гэмт хэрэг үйлдсэн этгээд юм. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг нарийн зөв тогтоох зорилгоор гэмт хэрэг үйлдсэн этгээдэд байх хууль цаазын шинжүүдийг тодорхойлдог.

46 www.new.shuukh.mn

Гэмт хэрэг үйлдсэн этгээд нь нийгэм, улс төр, эрх зүй, биологийн болон бусад хувийн онцлог шинжүүдтэй байдаг боловч тэдгээр нь бүгд гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын шинжид хамаардаггүй юм. Учир нь эдгээр шинж бүхэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд эрүүгийн эрх зүйн хувьд ач холбогдолгүй.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүдийг тэдгээрийн субъектын шинжээс нь хамаарч нийтлэг субъекттэй гэмт хэрэг, тусгай субъекттэй гэмт хэрэг гэж ангилдаг. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн, 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай байна.

Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр

Гэм буруу гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрүүгийн хуульд заасан өөрийн гэмт үйл ажиллагаа тухайлбал нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас учрах хор уршгийг хэрхэн ойлгож ухамсарласан сэтгэхүйн харьцааг хэлнэ. Гэм буруугийн хэлбэрийг хууль тогтоогч гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжийг заахдаа гэм буруугийн хэлбэрийг шууд ба шууд бусаар тогтоож өгсөн байна.



Гэмт хэрэг үйлдсэн сэдэлт гэдэг нь гэмт этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд өдөөж түлхэж байгаа, хүний тодорхой ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагаар нөхцөлдсөн сэтгэхүйн дотоод хүчин зүйлийг хэлнэ. Гэмт хэрэг үйлдсэн сэдэлт нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын анхдагч шинж, гэмт этгээдийн өөрийн нийгэмд аюултай гэмт үйл ажиллагаандаа харьцах сэтгэхүйн харьцааг үүсгэж байдаг анхдагч ойлголт юм. Учир нь гэмт этгээдэд гэмт хэрэг үйлдэхэд өдөөж түлхэж байгаа өдүүлбэр-сэдэлт анхлан бий болсноор гэмт хэрэг үйлдэх гэсэн гэмт санаа бодол үүсэх ба үүнээс уламжлан өөрийн үйлдэх гэмт үйл ажиллагаандаа хандах сэтгэл зүйн харьцаа-гэм буруугийн асуудал бий болно.

Гэмт хэрэг үйлдсэн зорилго нь гэмт этгээд гэмт хэрэг үйлдэх явцад хүрэхийг эрмэлзсэн үр дүн мөн. Гэмт хэрэг үйлдсэн зорилгын тухай асуудал нь гэм буруугийн санаатай тухайлбал урьдаас төлөвлөсөн шууд санаагаар үйлдсэн гэмт хэрэг дээр эрүүгийн эрх зүйн хувьд ач холбогдолтой. Гэм буруугийн энэ санааны үед гэмт этгээд гэмт хэрэг үйлдэхдээ тодорхой хор уршгийг учруулахыг урьдаас хүсэх ба энэхүү хор уршгийг учруулахад түүний зорилго чиглэж байдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэх бөгөөд хохирогчийн биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих тусгай зорилготой байна⁴⁷.

- “Биеийг нь үнэлүүлэх” гэж хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг бусадтай төлбөртэйгээр бэлгийн харьцаанд оруулахыг ойлгоно.

47 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги, УБ.,2019

- “Бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах” гэж хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг садар самуун сурталчилсан кино, дүрс бичлэг, тайчих үзүүлбэр, тоглолт, уралдаан, тэмцээнд оруулахыг ойлгоно.
- “Боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах” гэж хүн бусад хүнийг хүчээр өөрийн өмч болгон өөрийн дур хүсэл, сонирхлын дагуу ажиллуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүнийг төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.
- “Эд эрхтнийг авах” гэж гэмт этгээд өөрийн болоод бусдын бие, эд, эрхтнийг нөхөн сэргээх, аль нэг эрхтнийг орлуулан солих, эсхүл бусдад худалдаалж ашиг олох зорилгоор хүний эд, эрхтнийг авсныг ойлгоно.
- “Албадан хөдөлмөрлүүлэх” гэж хүний хүсэл зоригийн эсрэг илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, аливаа ажил үйлчилгээг цалин хөлсгүй гүйцэтгүүлэхийг ойлгоно.



Шигтгээ 2

...Жуковт очоод байж байтал Х, Х ах хоёр гараад явсан ба би ирэхгүй удаад байхаар нь гарах гэтэл гэрийнх нь үүдэн дээр Х ахтай таарчихсан. Х намайг “чи хаачих гэж байгаа юм, нэг явсан бол наад ажилдаа дасаад яв мэдэв үү, алив цаашаагаа ор” гэхээр нь би “би явмаар байна” гэтэл “цаашаа ор” гээд миний толгой руу гараараа нэг удаа цохисон. ...Тэгээд маргааш нь 20 цаг хүртэл Х ах намайг гаргаагүй ба орой 20 цаг өнгөрөөгөөд Х ах Х бид хоёрыг авч гарахад надад 4-5 дуудлага ирсэн. Би бүх дуудлаганд очсон ба Х надтай хамт орж миний мөнгийг аваад гарсан. 1-2 хүн нь мобайл банкаар 80.000-100.000 төгрөг мобайлдаж шилжүүлсэн. Тэгэхдээ би 4-5 хүнтэй нь бэлгийн харьцаанд орсон.

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 1034 дугаартай шийтгэх тогтоолоос

Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал

Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмын дагуу тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ. Иймээс мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж үзэх болон хүндрүүлэх шинж байгаа эсэхийг заавал тогтооно.

Зураг 10. Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлууд

Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж үзэх нөхцөл байдлууд						
Тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн;	Гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид шууд эмнэлгийн, бусад туслалцаа үзүүлсэн, учруулсан хохирлыг төлсөн;	Бие махбодын, сэтгэл санааны албадлагын, эд хөрөнгийн, албан тушаалын, бусад байдлаар эрхшээлд орсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;	Хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн;	Өөрийгөө илчилсэн, бусдын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг олоход тусалсан;	Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;	Байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор хохирогчид халдаж гэмт хэрэг үйлдсэн.

Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлж үзэх нөхцөл байдлууд



бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн;

энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн;

нийтэд аюултай аргаар үйлдсэн;

өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн;

албан үүргээ гүйцэтгэх, олон нийтийн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хохирогч, түүний ойр дотны хүний эсрэг үйлдсэн;

хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн;

онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн;

гэм буруугаа хүлээж хохирлоо төлөх үүрэг хүлээсэн хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй.

Зураг 11. Хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх шинж



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигийн шинж чанар, хэр хэмжээ

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно. Харин мөн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно.

Хохирлын хэмжээг нарийвчлан тогтоох нь хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон цаашид уг гэмт хэргийг зүйлчлэхэд ихээхэн ач холбогдолтой байдаг тул хохирлын хэмжээг доор дурдсанаар ойлгоно.

* "их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу 50,000,000 төгрөг, түүнээс дээш хэмжээг;

- * “үлэмж хэмжээний хохирол” гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу 10,000,000 төгрөг, түүнээс дээш хэмжээг;
- * “бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу 300,000 төгрөг, түүнээс доош хэмжээг.

Хүнийг худалдаалахдаа хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хяналтандаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдах аргаар хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан идэвхтэй үйлдлийг хэлэх бөгөөд эдгээр үйлдлүүдийн аль нэгийг хийснээр төгсдөг, хэлбэрийн шинжтэй, гэмт хэргийн улмаас хохирол, хор уршиг учирсан байхыг шаарддаггүй онцлогтой юм.

Зарим судалгааны үр дүнгээс харахад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нар нь эрх зүйн мэдлэг, өмгөөлөл хууль зүйн туслалцаа авч чадахгүй байх зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан хохирол нэхэмжлэхгүй орхих, нэхэмжилсэн хохирлоо нотлох баримтаар тогтоолгож чадахгүй байх, үүнээсээ болоод шүүхээс нэхэмжилсэн хохирлыг хэлэлцэлгүй орхиж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлүүлэх эрхтэйгээр хэргийг шийдвэрлэх зэрэг байдалд хүрдэг байна.

Нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан болон эрүүл мэндийн мэргэжилтнүүд нь анхны асуумжийн дагуу ярилцлагыг явуулахдаа хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой нэр төр, алдар хүнд, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгийн ямар хохирол, хор уршиг учирсан талаар лавлаж тодруулаарай.

Улмаар тухайн хохирол барагдуулах, хор уршигийг арилгуулах арга хэмжээг хуулийн байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлж, гэм буруутай этгээдээр төлүүлэх боломжтой талаарх мэдээллийг хохирогчид сайтар өгч, шаардлагатай баримт бичиг бусад зүйлсийг гаргаж өгөх болон олж авахад нь дэмжлэг үзүүлээрэй.

ХОЁР

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ-ХҮҮХДИЙН ӨМГӨӨЛҮҮЛЭХ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

- 2.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хохирогч-хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн эрх, үүрэг
- 2.2 Өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах
- 2.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах үндэслэл, журам

2.1

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ХОХИРОГЧ-ХҮҮХЭД, ТҮҮНИЙ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хүүхдийн эрхийн конвенц, 19-р зүйл

Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зарим хуульд “хохирогч” гэх нэр томъёог янз бүрээр тайлбарласан байдаг. Үүнээс хохирогч төвтэй хандлагатай, хуульд заасан туслалцаа дэмжлэг авахдаа заавал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хохирогчоор тогтоогдсон байхыг шаарддаггүй онцлогтой хуулийн тайлбар нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль юм.

Хүснэгт 5. Үндэсний зарим хууль тогтоомжид хохирогч тодорхойлолтыг хэрхэн тусгасан бэ?

Хууль	Тодорхойлолтууд
Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль ⁴⁸	3.1.2. Хохирогч гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн хүнийг хэлнэ.
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль ⁴⁹	5.1.2. “гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” /цаашид “хохирогч” гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль ⁵⁰	4.1.1. “Гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг ойлгоно.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ⁵¹	8.1. Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль ⁵²	3.2. “Хохирогч” гэж зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан зөвхөн ЭХХШТХ-ийн дагуу явагдана, 1.6 дугаар зүйлд Шүүх, прокурор, мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн

48 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2012, №07

49 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №05

50 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2013, №30

51 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №23


52 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №24

заалтыг чанд сахина. ЭХХШТХ-д зааснаас өөрөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх хэм хэмжээ тогтоосон журам гаргахыг хориглоно гэж заасан. Иймд цаашид энэ бүлэгт авч үзэх хохирогчтой холбоотой агуулгыг ЭХХШТХ-ийн агуулгын хүрээнд авч үзэх нь зүйтэй.

ЭХХШТХ-ийн 8.1 дүгээр зүйлд гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ. Хохирогчоор тогтоох шийдвэрийг мөрдөгч, прокурор, шүүгч гаргах бөгөөд хохирогч нь мөн хуулийн 8.2 дугаар зүйлд заасан дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

1. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;
2. хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;
3. мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
4. шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох;
5. шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;
6. шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;
7. эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
8. хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах;
9. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;
10. шүүхийн цагаатгах, шийтгэх тогтоолын хувийг авах;
11. шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
12. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;
13. шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах;
14. өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;
15. энэ хуульд заасан бусад эрх.

Хохирогч дээр дурдсан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болохоор хуульчилсан нь насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар авсан арга хэмжээ болсон байна.



Ямар ч тохиолдолд насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгч оролцох нь зайлшгүй бөгөөд хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзсэн онцгой тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болох зохицуулалттай.

Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11.5 дугаар зүйлд хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүний асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ, мөн хуулийн 11.7 дугаар зүйлд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй хэмээн хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзсэн чухал зохицуулалт байдаг.

Хүүхэд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохироход тэдний гэр бүлийн гишүүдийн үүрэг оролцоо тодорхой хэмжээнд байдаг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулж, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас хууль ёсны төлөөлөгчийг заавал томилж, тэднийг хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалж ажиллах талаар хариуцлагажуулах хэрэгтэй.

Тухайлбал энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг байгууллагын төлөөлөл *"...Дан ганц ХХГХ-ийн хохирогчоос гадна насанд хүрээгүй бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын хууль ёсны төлөөлөгчийн асуудал өнөөдөр төвөгтэй хэвээр байна. Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, эсвэл эцэг эх тухайн хүүхдийг гэмт хэргийн хохирогч болоход ашиг сонирхлын зөрчилдөөнтэй зэрэг шалтгаанаар ГБХЗХГ-аас хууль ёсны төлөөлөгчийг тогтоох асуудал түгээмэл байдаг. Гэхдээ хууль ёсны төлөөлөгчөөр ордог хүмүүсийг тодорхой хэмжээгээр бэлдэх хэрэгтэй гэж бодож байна. Асуудлуудаа тодорхой зөв тавьж чаддаг, үнэхээр хүүхдийн төлөө байж, хүүхдийн төлөө гаргаж чадах асуудлуудыг тавьж чадах, тодорхой хэмжээний мэдлэгтэй, түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хамгаалах асуудал дутагдалтай байна. Зарим хүмүүс чинь ажил төрлөөсөө гарах, өөрчлөгдөх тохиолдол байна, тэр тохиолдолд тун хурдан хугацаанд хууль ёсны төлөөлөгчийг дахин томилохгүй бол хэрэг нь цагдаагийн газар ч юм уу, прокурор дээр хянагдаж байгаад хэрэгсэхгүй болгоод хаагдчихдаг. Тэгээд нөгөө ээж аав нь мэдэх боломжгүй, хэрэгт оролцох эрхгүй байдаг. Нөгөө хууль ёсны төлөөлөгчид хэлэх гэхээр хууль ёсны төлөөлөгч нь холбогдохгүй байдаг. Тэгээд хэрэг нь хэрэгсэхгүй болоод хаагдах ийм нөхцөл байдлууд гарч байна"* хэмээн мэдэгдэж байжээ⁵³.

Хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд нь ЭХХШТХ-ийн 9.5.4 дэх хэсэгт зааснаар хохирогчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

Хууль ёсны төлөөлөгчөөр оролцож буй этгээд нь:

- ✓ хүүхдийн язгуур эрх, ашиг сонирхлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хамгаалах;

53 Дэлхийн зөн Монгол ОУБ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ.,2021

- ✓ насанд хүрээгүй хохирогчийг оролцуулан явуулж буй мөрдөн шалгах бүхий л ажиллагаанд биечлэн оролцож, шаардлагатай хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах талаар хүсэлт гаргаж шийдвэрлүүлж байх;
- ✓ хууль зүйн туслалцаа авах шаардлагатай бүх арга хэмжээг авах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгчтэй оролцож байхад анхаарах;
- ✓ хүүхдэд учирсан хохирлыг нэхэмжлэх, шаардлагатай нотлох баримтуудыг мөрдөгч, прокурор, шүүхэд гаргаж өгч, хэргийн хамт шийдвэрлүүлэхэд анхаарах учиртай.

Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон мэргэжилтнийг тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд тогтвортой ажиллах бүх бололцоогоор хангах нь олон улсын гэрээгээр хүлээсэн болон үндэсний хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж буй нэг илрэл болно.

2.2

ӨМГӨӨЛҮҮЛЭХ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй гэжээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараах хууль, хэм хэмжээ тогтоосон акт үйлчилж байна.

Хууль, хэм хэмжээний акт	Зохицуулалт
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	<p>5.1 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх, үүрэг 1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.</p>
	<p>5.2 дугаар зүйл.Өмгөөлөгчийг сонгох 1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч өмгөөлөгчөө өөрөө сонгоно. 2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн зөвшөөрснөөр, эсхүл хүссэнээр тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь өмгөөлөгч сонгож болно. 3.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг өмгөөлөгчөө сонгох боломжоор хангахдаа шүүгч, прокурор, мөрдөгч тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй.</p>

	<p>4.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч өмгөөлөгчөөсөө татгалзсан бол түүнд өөр өмгөөлөгч сонгох боломж олгоно.</p> <p>5.Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах журмыг хуулиар тогтооно.</p> <p>5.3 дугаар зүйл.Өмгөөлөгч оролцуулах</p> <p>1.Дараахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй:</p> <p>1.1.хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй;</p> <p>1.2.өсвөр насны;</p> <p>1.3.монгол хэл, бичиг мэдэхгүй;</p> <p>1.4.бүх насаар хорих ял оногдуулж болох;</p> <p>1.5.хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;</p> <p>1.6.төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан.</p> <p>8.1 дүгээр зүйл.Хохирогч</p> <p>3.Хохирогч энэ хуульд заасан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.</p>
<p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль</p>	<p>12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ</p> <p>12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ:</p> <p>12.1.1.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ;</p> <p>12.1.2.сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ;</p> <p>12.1.3.ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах;</p> <p>12.1.4.хууль зүйн туслалцаа;</p> <p>12.1.5.гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах.</p> <p>12.2.Энэ хуулийн 12.1.1, 12.1.2-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 12.1.3-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 12.1.4-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 12.1.5-д заасан үйлчилгээ үзүүлэх журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална.</p>
<p>Гэрч, хохирогчийг хамгаалах тухай</p>	<p>18 дугаар зүйл.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа</p> <p>18.1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлж болно:</p> <p>18.1.1.хууль зүйн туслалцаа;</p> <p>18.1.2.сэтгэл зүйн туслалцаа;</p> <p>18.1.3.эрүүл мэндийн туслалцаа.</p> <p>18.1.4.нийгмийн бусад туслалцаа.</p> <p>18.4.Энэ хуулийн 18.1.1-д заасан хууль зүйн болон 18.1.2-т заасан сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4-т заасан алба тус тус хариуцан хэрэгжүүлнэ.</p> <p>5 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны төрөл</p> <p>5.1.Хууль зүйн туслалцаа нь дараах төрөлтэй байна:</p> <p>5.1.1.хууль зүйн зөвлөгөө өгөх;</p> <p>5.1.2.өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх;</p> <p>5.1.3.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх.</p>

<p>Хууль зүйн туслалцааны тухай хууль</p>	<p>6 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүн 6.1.Доор дурдсан хүн /цаашид “үйлчлүүлэгч” гэх/-д энэ хуульд заасан журмын дагуу өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлнэ: 6.1.1.Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, Арван дөрөвдүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, Арван зургадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан; 6.1.2.Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан; 6.1.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд. 6.2.Доор дурдсан хүүхдэд түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлтээр өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлж болно: 6.2.1.гэмт хэргийн гэрч хүүхэд; 6.2.2.Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих/, 6.20 дугаар зүйл /Хүүхдийн эрхийг зөрчих/-д заасан зөрчлийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхэд. 6.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хүсэлтийн дагуу хууль зүйн туслалцаа үзүүлж болно.</p> <p>9 дүгээр зүйл.Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг 9.1.Үйлчлүүлэгч дараах эрхтэй: 9.1.1.хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах; 9.1.2.улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэрийн талаар хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад, өмгөөллийн үйлчилгээний талаар холбогдох эрх бүхий байгууллагад, хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус гомдол гаргаж шийдвэрлүүлэх, шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах; 9.1.3.хуульд заасан бусад.</p>
<p>Өмгөөллийн тухай хууль</p>	<p>29 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа 29.1.Өмгөөлөгч нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлнэ. 29.2.Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр, журмыг Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөл батална. Төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг Өмгөөлөгчдийн Холбоо эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулна.</p>
<p>Хүүхэд хамгааллын тухай хууль</p>	<p>10 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ 10.1.Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараахь хариу үйлчилгээ үзүүлнэ.</p>

	<p>10.1.1.мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах; 10.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх; 10.1.3.аюулгүй байдлыг хангах; 10.1.4.дэмжих, холбон зуучлах; 10.1.5.хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх; 10.1.6.гэр бүлд нь эргэн нэгтгэх.</p> <p>15 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээ</p> <p>15.1.Аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараах үйл ажиллагаа явуулна:</p> <p>15.1.1.гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх; 15.1.2.сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх; 15.1.3.гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах; 15.1.4.хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах; 15.1.5.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох; 15.1.6.хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах; 15.1.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах; 15.2.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын албаны үүргийг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.</p>
<p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам⁵⁴</p>	<p>1.1.Энэхүү журмын зорилго нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх Хүүхдийн эрхийн хорооны хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахал оршино.</p> <p>3.1.Хороо нь зөрчил, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед болон дараагийн шатанд хохирогч, гэрч, хууль зөрчсөн хүүхдийн эрх ашгийг хангах хамгаална.</p> <p>4.9.Монголын хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч дараах үүрэг хүлээнэ.</p> <p>4.9.1.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хууль зөрчсөн, гэрч, хохирогч хүүхдийг төлөөлж холбогдох байгууллагад санал, хүсэлт, гомдол гаргах, хүүхдэд тулгарч буй асуудлаар хороог мэдээллэх хангах</p> <p>5.2.Хороо нь гэмт хэргийн хохирогч хүүхдэд дараах туслалцаа үйлчилгээг үзүүлнэ.</p> <p>5.2.7.өмгөөлөгч авах хүсэлтэй, төлбөрийн чадваргүй хохирогч хүүхдийн эрхийг хангах асуудлаар хорооны хуралд санал оруулж шийдвэр гаргуулах</p>

ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлд хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй. Түүнчлэн УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталснаар

54 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/51, А/69 дүгээр тушаал

хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, төлбөрийн чадваргүй иргэн өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авч чадах эрх зүйн орчин бүрджээ.

Хуулиар дараах тохиолдолд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг үзүүлнэ.



Төлбөрийн чадваргүй хүн хуульд заасан хууль зүйн туслалцааг авахын өмнө төлбөрийн чадваргүй болохоо үнэн зөв мэдүүлэх үүрэг хүлээх бөгөөд үнэн зөв мэдүүлээгүй бол хуулийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулжээ. Төлбөрийн чадваргүй болохоог дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

1. Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
2. Дээрх өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болох нь тухайн иргэний өргөдөл болон баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, бусад нотлох баримтаар тогтоогдсон иргэн.

Дээр дурдсан иргэн өмгөөллийн үйлчилгээ авах бол хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад өргөдөл гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй үйлчлүүлэгчийн хувьд баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, бусад нотлох баримт бичиг;
- Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх бол холбогдох нотлох баримт бичиг;
- Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд бол эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

- Гэмт хэргийн хохирогч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлт;
- Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн хүсэлт гэх мэт.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийг хэрэгжүүлэх, өмгөөлөл, хууль зүйн туслалцааг хуульд заасны дагуу үзүүлэхтэй холбоотой дараах журам хэрэгжих юм. Үүнд:

- Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн,
- Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлыг уялдуулан зохицуулах зорилгоор ажиллах орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн,
- Хууль зүйн туслалцааны мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хамгаалах, мэдээлэл солилцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
- Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүй, санхүү, төсвийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран,
- Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран,
- Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирал, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч хамтран тус тус батална.

2.3

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэг онцлог зохицуулалт нь гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах бие даасан зохицуулалт юм. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, ЭХХШТХ-д заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргана.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан дараахь аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх шийдвэр гаргана. Үүнд:

1. тодорхой үйлдлийг хязгаарлах;
2. биечилсэн хамгаалалтад авах;
3. мэдээллийн нууцлалыг хангах;
4. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах.

Гэрч, хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээ авах тухай шийдвэрт дараахь зүйлийг тусгана. Үүнд:

- аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;
- аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;
- аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;
- аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага.

Хүснэгт 6. Аюулгүй байдлын хамгаалалтын төрөл, түүний агуулга

<p>Тодорхой үйлдлийг хязгаарлах</p>	<p>Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна. Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан эрх бүхий албан тушаалтан хязгаарлах арга хэмжээ авахуулсан этгээдээр гарын үсэг зуруулж, түүнд хяналт тавина.</p>
<p>Биечилсэн хамгаалалтад авах</p>	<p>Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна. Биечилсэн хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.</p>
<p>Мэдээллийн нууцлалыг хангах</p>	<p>Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна.</p> <p>Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах, зохиомол нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>Эрх бүхий албан тушаалтан иргэний бүртгэлийн, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн болон хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно.</p> <p>Гэрч, хохирогчийн нууцалбал зохих мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд танилцуулж болно.</p>
<p>Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах</p>	<p>Гэрч, хохирогчийг Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12.1-д заасан гав, хүлэг, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резинэн ба хуванцар сумтай буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.</p>

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллага гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, хамгаалалтын арга хэмжээ авах талаар шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандах шаардлагатай байна.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд аюулгүй байдлын хамгаалалтад авагдсан хохирогчид дараах дөрвөн төрлийн туслалцаа үзүүлэх зохицуулалттай. Үүнд:

1. Хууль зүйн туслалцаа
2. Сэтгэл зүйн туслалцаа
3. Эрүүл мэндийн туслалцаа
4. Нийгмийн бусад туслалцаа.

Эдгээр үйлчилгээнээс хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцаа, эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ. Харин нийгмийн бусад туслалцааг үзүүлэх үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Хуулийн хүрээнд хохирогч, гэрч нарт үзүүлэх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлт хяналт тавих чиг үүргийг холбогдох байгууллагуудад хүлээлгэсэн байна. Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийг даган гарсан дараах журмууд байдаг. Үүнд:

- Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам⁵⁵,
- Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам⁵⁶,
- Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам⁵⁷

Дээрх баримт бичгүүдэд насанд хүрээгүй хохирогчийн нас сэтгэхүйн онцлогийг үйлчилгээнд харгалзах, тусгайлсан зохицуулалт байхгүй байгаа нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдэд аюулгүй байдлын хамгааллын үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар тусгайлсан зохицуулалт дутмаг байгааг харуулж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар их, хохирогч, ялангуяа насанд хүрээгүй хохирогчийг болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан аюулгүй газарт түр байрлуулах арга хэмжээг хэрэглэж болно.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд шаардлагатай тохиолдолд насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана гэж заасан.

55 Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал

56 Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаал

57 Хууль зүйн сайдын 2014 оны А/112, А/113, А/114 дүгээр тушаал,

Харин Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллана. Хохирогч болсон гэж өөрийгөө үзсэн этгээд хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллага, эсхүл хамгаалах байрны захиргаанд гаргана. Ийнхүү хүсэлт гаргасан хүнд түр хамгаалах байраар үйлчилгээ үзүүлэх шаардлагатай гэж үзвэл хүн худалдаалах гэмт хэргийг цагдаагийн болон тагнуулын байгууллага шалгаж эхэлсэн эсэхийг үл харгалзан хохирогчийг хамгаалах байранд түр байрлуулна.

Хамгаалах байранд буй хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн эцэг, эхийг нэн даруй олж тогтоох арга хэмжээг авах бөгөөд хүүхдийн эцэг, эхийг олж тогтоогоогүй тохиолдолд түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тухайн сум, дүүргийн Засаг дарга томилно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг түр хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулах бөгөөд Хүүхэд хамгааллын тухай болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, стандартад заасан бүхий л үйлчилгээг үзүүлнэ (энэ талаар Модуль 7-д авч үзсэн).

ХАВСРАЛТ

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ АСУУЛГА

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1.	Нас:			
2.	Иргэншил:			
3.	Ажил эрхлэлт			
4.	Өр, зээлтэй эсэх			
5.	Цалин хөлстэй эсэх			
Үндсэн үзүүлэлт				
<i>Зөвлөмж:</i>				
<ul style="list-style-type: none"> – Ярилцлага хийж буй албан хаагч нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих, – Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтанд орох эрсдлийг бий болгож байдгийг анхаарах, – Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах, – Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих. – Ярилцагчид тавигдаж буй асуултууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдрэх хэрэгтэй. – Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй. 				
<i>Биеэ үнэлэх, биеийг нь үнэлүүлэхтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох</i>				
6.	Та хэзээнээс биеэ үнэлж эхэлсэн бэ? Таныг биеэ үнэлэхэд хэн нэгэн татан оруулсан уу? /цаг хугацаа, явц, хэн татаж оруулсан, таних эсэх/			
7.	Та биеэ үнэлнэ гэдгээ мэдэж байсан уу?			
8.	Та биеэ үнэлэх талаар мэдээгүй байсан бол хэрхэн биеэ үнэлэх болсон бэ?			
<i>Бэлгийн мөлжлөгтэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох:</i>				
9.	Биеэ үнэлэх явцдаа хэн нэгний /хамтран ажилладаг, худалдан авагч гэх мэт/ дарамт, хүчирхийлэлд орж байсан уу?			
	Эсвэл бусад биеэ үнэлэгч ийм байдалд орж байсан талаар сонссон зүйл бий юу?			
10.	Таныг биеэ үнэлдэг гэдгийг олон нийтийн сүлжээгээр эсвэл өөр бусад байдлаар бусдад тараана, мэдэгдэнэ гэж айлган сүрдүүлж байсан уу?			

11.	Таны биеийг үнэлүүлдэг этгээдийн зүгээс хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудтай дотно харилцаатай талаараа ярьж байсан уу?			
12.	Монгол Улсын хуулиар биеэ үнэлсэн хүн ч мөн хариуцлага хүлээдэг гэж айлган сүрдүүлж, явуулж буй хууль бус ажиллагаагаа нуух, энэ талаар мэдээлэх боломжийг хязгаарлаж байсан уу?			
13.	Ажил олгогчийн зүгээс таны зургийг авах, бэлгийн харилцааны үеийн болон тийм шинжтэй үйлдлийн бичлэгийг хийдэг байсан уу?			
<i>Хянан харгалзах болон дарамт шахалттай холбоотой нөхцлийг тодорхойлох:</i>				
14.	Амьдарч байсан орон байрнаасаа чөлөөтэй гарч орох боломжтой байсан уу?			
	Хэрэв боломжгүй байсан бол ямар нөхцөл байдал байсан бэ?			
	Хэний зөвшөөрлөөр гадагш гарах боломжтой байсан бэ?			
15.	Амьдарч байсан орон байрны чинь гадна болон дотор талд хяналтын камер байсан уу?			
	Амьдарч байсан орон байрны цонх эсхүл хаалганд хаалт байсан уу?			
16.	Гадна орчин үл харагдах өнгөөр будсан, өөр бусад зүйлсээр битүүлсэн байсан уу?			
	Ажил олгогч, үйлчлүүлэгчийн хий гэсэн ажлыг үл хийх нь таныг ямар нөхцөл байдалд оруулдаг байсан бэ?			
17.	Ажил олгогчийн зүгээс бэлгийн хүчирхийлэл үйлдэж байсан уу?			
18.	Амралтын өдөр гэж байгаа юу?			
	Байдаг бол хэзээ, хичнээн цаг амардаг байсан бэ?			
19.	Өөрийн хүссэн үедээ энэ ажлыг хийхээс татгалзах боломж байсан уу? Яагаад?			
20.	Хувийн бичиг баримтыг өөртөө байлгах боломж байсан уу?			
<i>Үйлчилгээ авах, хэрэгцээгээ хангах, цалин хөлстэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох:</i>				
21.	Амьдралын наад захын хэрэгцээ болох хоол ундныхаа хэрэгцээгээ хязгаарлуулж байсан тохиолдол бий юу?			
22.	Эрүүлмэндийнэмчилгээ, үйлчилгээ авах эрхээ хязгаарлуулж байсан уу?			
23.	Цалин өгдөг үү?			
	Өгдөг бол ямар хэмжээний цалин өгдөг вэ?			
	Цалингаа өгөхгүй байх ямар тохиолдол байсан бэ?			
24.	Үйлчлүүлэгч төлбөрөө төлөхгүй байх нь танд эрсдэл бий болгож байсан уу?			
	Тийм бол ямар эрсдэл үүсч байсан бэ?			
Тэмдэглэл:				

ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ АСУУЛГА

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1.	Нас:			
2.	Иргэншил:			
3.	Ажил эрхлэлт			
Үндсэн үзүүлэлт				
<i>Зөвлөмж:</i>				
<ul style="list-style-type: none"> - Ярилцлага хийж буй албан хаагч нь дор тавигдсан асуултаас гадна харилцагчийн яриа, бусад нөхцөл байдал, өөрийн мэдрэмжээр асуултуудыг нарийвчлан тодруулах замаар хохирогч мөн эсэхийг тогтоохыг зорих, - Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогчид болж өнгөрсөн үйл явдлын талаар олон удаагийн давтамжтай ярих нь сэтгэл зүйн дарамтанд орох эрсдлийг бий болгож байдгийг анхаарах, - Ярилцлагын явцад хүний наймааны хохирогч, биеэ үнэлэгч, мөлжлөгт өртөгч гэх мэт үгсийг аль болох ашиглахаас татгалзах, - Хохирогч төвтэй хандлагатай, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ярилцлагын асуултыг аль болох ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгөх замаар тодорхой хариулт авахыг зорих. - Ярилцагчид тавигдаж буй асуултууд, түүнд хариулж буй байдалд логик байгаа эсэх, үнэн эсхүл худал ярьж байгааг мэдрэх хэрэгтэй. - Ярилцлагын явцад өөр бусад хохирогч болсон эсхүл хохирогч байх магадлалтай хүмүүсийн талаарх мэдээлэл гарвал түүнийг тусгайлан тэмдэглэж, олж тогтооход анхаарах нь зүйтэй. - Шалган нэвтрүүлэх албаны ажилтан нь тухайн этгээдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж магадгүй гэх үндэслэл байвал нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага эсхүл тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж, шуурхай арга хэмжээг авна. 				
4.	Та ямар ажлаар гадаад улс руу зорчих гэж байгаа вэ?			
5.	Та хаанаас /аль аймаг, хот/ ирсэн?			
6.	Та өөрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаарыг хэлнэ үү?			
7.	Та гадаад паспортоо хэзээ авч байсан бэ?			
8.	Таны бусад бичиг баримтууд таны биед байна уу?			
	Байгаа бол үзүүлнэ үү?			
9.	Та хэн нэгэн хүнтэй хамт явж байгаа юу?			
	Хэрэв тийм бол хэнтэй хамт явж байгаа вэ?			
	Тантай ямар хамааралтай хүн бэ?			
	Та өмнө нь тухайн хүнтэй хамт гадаад улсыг зорьж байсан уу?			
	Та 2 хаанаас /аль аймаг, хот/ ирсэн бэ?			
10.	Та очих гэж буй тухайн улсдаа байгаа Элчин сайдын яам, Консулын газрын талаарх мэдээллийг мэдэх үү?			
<i>Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг тодруулах</i>				
11.	Таныг хэн нэгэн гадаад гадаад улсад ямар нэгэн ажилд зуучилж байгаа юу?			
	Хэрэв тийм бол аль улсад ажиллахаар явж байгаа вэ?			

12.	Тантай ажил гүйцэтгэх эсвэл хөдөлмөрийн гэрээ байгуулсан уу? Тийм бол түүнийгээ үзүүлнэ үү?			
13.	Таныг ажилд зуучилсан хүн эсвэл байгууллага хөдөлмөр зуучлалын албан ёсны зөвшөөрөлтэй байсан уу?			
14.	Та гадаад улс руу зорчих зардлаа өөрөө гаргаж байгаа юу?			
	Хэрэв та өөрөө зардлаа гаргаагүй бол таныг зардлыг хэн хариуцаж байгаа вэ?			
	Энэ талаар гэрээнд тусгасан зүйл бий юу?			
15.	Та гадаад улс руу ямар хугацаагаар явж байгаа вэ?			
<i>Суралцахтай холбоотой асуудлыг тодруулах</i>				
16.	Та суралцахаар явж буй сургуулийнхаа талаар хаанаас мэдээлэл авсан бэ?			
	Танд сургуулийн талаар мэдээлэл өгсөн хүн тантай хамт явж байгаа юу?			
17.	Танд тухайн суралцах сургууль болон сургалтыг зуучилсан байгууллага нь албан ёсны зөвшөөрөлтэй байсан уу?			
	Та гадаадад суралцахтай холбоотой гэрээ байгуулсан уу?			
	Таныг гадаад улсад очиж суралцахтай холбоотой сургалтын төлбөрөөс бусад зардлыг хэн хариуцаж байгаа вэ?			
	Таны сургалтын төлбөрийг хэн хариуцаж байгаа вэ?			
Тэмдэглэл:				

ЭРСДЭЛ БҮХИЙ ГАДААДЫН ИРГЭНЭЭС АВАХ АСУУЛГА

№	Асуулт	Тийм	Үгүй	Дэлгэрэнгүй мэдээлэл тэмдэглэх
Суурь үзүүлэлт				
1.	Нас:			
2.	Иргэншил:			
3.	Ажил эрхлэлт			
4.	Цалин хөлстэй эсэх			
5.	Та Монгол хэл мэдэх үү, мэддэг бол ямар түвшинд мэддэг вэ?			
6.	Монголд хэзээ, хэрхэн, хэнтэй, яаж ирсэн бэ?			
7.	Таниас зөвшөөрөл авалгүйгээр визний хугацааг сунгах, ажлын байр өөрчлөх тохиолдол гарч байсан уу?			
8.	Яагаад Монголд ирж ажиллах болсон бэ?			
	Таныг энд ирүүлэхийн тулд хэн хэгэн ятгах, дарамтлах зэргээр нөлөөлсөн үү?			
9.	Таны ирэх зардлыг хэн хариуцсан бэ?			
10.	Та одоо Монголд ямар нөхцөлд ажиллаж амьдарч байна вэ?			
11.	Та өдөрт, долоо хоногт хэдэн цаг ажилладаг вэ?			
12.	Та одоо эрхэлж байгаа ажлаа хийж эхлэхдээ хөдөлмөрийн ямар нэгэн гэрээ байгуулсан уу?			
13.	Танд мэдээлэл, харилцаа, холбооны хэрэгсэл ашиглах боломж байдаг уу?			
14.	Ажил олгогч тантай анх тохирсноосоо өөр эсвэл илүү ажил хийхийг санал болгох/шаардах тохиолдол гарч байсан уу?			
	Хэрэв тийм бол ямар ажил хийхийг санал болгосон бэ?			
15.	Таны иргэний бичиг баримтууд өөрт тань бий юу?			
16.	Та ажил олгогчдоо эсхүл таныг ажилд зуучилсан хүнд өртэй юу?			
17.	Та хийж буй хөдөлмөрийнхөө хөлсөнд хэдэн төгрөг авдаг вэ?			
	Ажил олгогч тантай анх тохирсны дагуу цалингаа бүрэн олгодог уу?			
18.	Таны олсон орлогоос хувь авдаг хүн бий юу?			
	Хэрэв тийм хүн байгаа бол хэд, хэдэн хувиар нь хуваадаг вэ?			
	Танд оногдох хувь таны амьдралд хүрэлцээтэй байдаг уу?			
19.	Таныг амьдарч байгаа орон байрнаасаа гарахыг хориглох тохиолдол гарч байсан уу?			
	Хэрэв тийм бол та тухайн үед ямар арга хэмжээ авсан бэ?			
20.	Нутаг руугаа буцах боломж байсан уу?			
Тэмдэглэл:				

НОМ ЗҮЙ

Эрх зүйн баримт бичиг

Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,1999, №30

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017,№5

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2013, №30

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2011. №8

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2019, №48

Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №41

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,1992, №1

Стандарт, хэмжил зүйн газар, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 5852:2017) стандарт

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2018, №5

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/51, А/69 дугаар тушаал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх” журам

Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2021, №31

Хууль зүйн сайдын 2014 оны А/112, А/113, А/114 дүгээр тушаал, Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 дүгээр тушаал

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2012, №7

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2017

Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, 2017.

Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016. №9

Шүүхийн шинжилгээний тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2009

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016, №21

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №3

Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 462-р тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх” журам

Судалгааны тайлан

- Азийн сан “Монголын уурхайн газар дах биеэ үнэлэлт ба хүний наймаа” судалгаа, 2008 он
- Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, Судалгааны тайлан, 2022
- АНУ-ын төрийн департамент, 2018 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- АНУ-ын төрийн департамент, 2019 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- АНУ-ын төрийн департамент, 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- АНУ-ын төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан
- Дэлхийн зөн Монгол ОУБ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, 2021
- НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа, 2018
- НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хүн худалдаалахын хохирогчийг илрүүлэх, ярилцлага авах болон тусламж үйлчилгээнд хамруулах тухай заавар, 2017
- НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээс хийсэн Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, УБ.,2021
- Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк, Ядуурлын дүр төрх, 2021
- Үндэсний статистикийн хороо, Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан-2017
- ХЗДХЯ, Азийн сан, ХТЭТ, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдыг чадавхыг үнэлэх судалгааны тайлан, 2017
- Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал” тайлан, 2010
- Хүйсийн тэгш эрхийн төв, ТББ, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал судалгааны тайлан, 2021

Ном, гарын авлага, илтгэл, өгүүлэл

- Гантулга С., Энхболд Б., Эрүүгийн эрх зүйн тусгай анги, УБ.,2019
- Жендэрийн үндэсний хороо, «Жендэр ба бодлого төлөвлөлт» Модуль сургалт 1-Жендэрийн сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ.,2018
- Жендэрийн үндэсний хороо, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргазүйн зөвлөмж, УБ.,2020
- Өнөрмаа Б., Ялгаварлан гадуурхалтын ойлголт, эрх зүйн зохицуулалт
- Түмэннаст Г., Боловсролын тэгш бус байдал ардчиллын өөрийнх нь хувь заяатай холбоотой асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрх төв ТББ, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх гарын авлага, УБ.,2022

Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага /хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг/, УБ.,2019

Хүүхдийг Ивээх Сан, Хамтарсан багийн гишүүдэд зориулсан гарын авлага, УБ.,2016

Энхчимэг С., Үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэг, ялангуяа хүн худалдахын эдийн засгийн логик, зах зээл хоорондын онцлог

Цахим хуудас

1. <http://mfa.gov.mn>
2. <https://iaac.mn>
3. <https://nhrcm.gov.mn>
4. <https://mn.usembassy.gov>
5. <https://tbinternet.ohchr.org>
6. <https://www.humanrightscareers.com>
7. <https://www.ilo.org>
8. <https://www.mei.edu>
9. <https://www.ncge.gov.mn>
10. <https://www.unfpa.org>
11. <https://www.unodc.org>
12. <https://www.who.int>
13. www.1212.mn
14. www.new.shuukh.mn
15. www.upr-mongol.mn

Гадаад хэл дээрх эх сурвалж

United Nations Children's Fund, A Familiar Face: Violence in the lives of children and adolescents, UNICEF, New York, 2017.



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

📺 HairaarUlgerley